

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
5 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.06.05

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хурал тайлант сард 1 удаа, Тэргүүлэгчдийн хурал 2 удаа хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн хурлаар:

-“Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын хуралдааны нийтлэг дэг”-ийн төсөл;
-“Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал өргөн барих, шийдвэр гаргуулах журам”-ын төсөл;

-Аймгийн 2017 оны тодотгосон төсвийн төсөл;

-Сэлэнгэ-Энерго” ОНӨААТҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай мэдээлэл;

-“Сэлэнгэ олон улсын худалдааны төв”-д талбай түрээслүүлэх журам”-ын төсөл

-“Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудал

-Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцсэн.

Дээрх асуудлуудтай холбогдуулан Засгийн газраас орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтласан зарчмыг үндэслэн Сэлэнгэ аймгийн ИТХ-ын ээлжит V хуралдаанаар аймгийн 2017 оны тодотгосон төсвийн орлого, зарлагын хэмжээг 64 132 279.2 мянган төгрөгөөр баталж, аймгийн төв Сүхбаатар хотыг дулаан хэрэглээний усаар хангадаг “Сэлэнгэ-Энерго” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагааны доголдлыг арилгах, өр зээлийн хэмжээг багасган, санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2004-2008 онуудад аймгийн төсвөөс урьдчилгаагаар олгож нүүрс, ус, цахилгааны төлбөрт зарцуулсан 744 462 230 төгрөгийн өр, авлагыг хүчингүй болгож төсвийн алдагдалд тооцохоор шийдвэрлэж, “Сэлэнгэ олон улсын худалдааны төв”-д талбай түрээслүүлэх журам, “Аймгийн ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал өргөн барих, шийдвэр гаргуулах журам”-ыг баталж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2, 3.3, 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4, 5 дугаар зүйлийн 5.2.2, 5.2.4, 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2006 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн хүндэтгэлийн дуу бий болгох тухай” тогтоолд аймгийн хүндэтгэлийн “Өргөн Сэлэнгэ” дууны шүлгийг зохиосон яруу найрагч Галдангийн Даваацэрэнгийн нэрийг ташаарч “Г.Даваасүрэнгийн шүлэг” гэснийг “Г.Даваацэрэнгийн шүлэг” гэж залруулах шийдвэрийг тус тус гаргасан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэж 17 тогтоол баталлаа. Үүнд:

-Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрөөс иргэд, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэд “Сэлэнгэ орон сууц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгууллаа.

-“Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх аймгийн хөтөлбөр батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн нийт хүн амд үзүүлэх эрүүл

мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг уртасгахад чиглэгдсэн “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн хөтөлбөр”-ийг баталлаа.

-Сүрьеэ өвчинтэй тэмцэх “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрийг баталлаа. “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийг баталснаар энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, эрт илрүүлгийг эрчимжүүлж, өвчтөний эмчилгээний үр дүнг нэмэгдүүлснээр сүрьеэгийн өвчлөл тархалтыг бууруулах юм.

-Эх хүүхдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын зорилтын талаарх аймгийн Эрүүл мэндийн газрын мэдээллийг сонсоод аймгийн Засаг дарга, аймгийн Эрүүл мэндийн газрын дарга, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт албан даалгавар өглөө.

-”Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг газрын улсын бүртгэлд бүртгэх журам”-ыг батлав.

-Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн, аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, ашигт малтмалын болон байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, гадаад дотоод харилцаа, борлуулалтад дэмжлэг үзүүлэх, аймгийн нутаг дэвсгэр дэх байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хуваарилах, ирээдүйд хуримтлал үүсгэн ажиллуулах зорилгоор орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулан ажиллуулах тухай саналыг хэлэлцээд “Сэлэнгэ-баялаг ирээдүй” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгууллаа.

-Үндсэн хөрөнгө актлах тухай асуудлыг хэлэлцээд олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа Санхүүгийн хяналт аудитын алба, Сүхбаатар сумын Тохижилт үйлчилгээний газар, Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль, Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сумын Цагдаагийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн УАЗ-31519 маркийн автомашин, аймгийн Цагдаагийн газрын 5-р багийн Цагдаагийн кабон зэрэг хөрөнгүүдийг үндсэн байгууллагын санал дүгнэлтийг үндэслэн тус тус актлахыг зөвшөөрөв.

-Үндсэн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах тухай асуудлыг хэлэлцээд олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баянгол сумын ЗДТГ, Мандал сумын 4-р багийн ЗДТГ, мөн сумын Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн хэлтэс, Сүхбаатар сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрч дуудлага худалдааны доод үнийг баталлаа.

-Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцээд аймгийн Нийтийн номын сангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд шилжүүлэх, Эрүүл мэндийн газрын хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Шаамар сумын ЗДТГ-т, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт бүртгэлтэй тээврийн хэрэгслийг Жавхлант сумын ЗДТГ-т, Зоонозын өвчин судлалын төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй алсын дуудлагын станцыг Хилийн 0243 дугаар ангид тус тус шилжүүлэхийг зөвшөөрлөө.

-Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцээд Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төв байгуулагдсаны 80 жилийн ойг 2017 оны 07 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрөв.

-Соёл, шинжлэх ухааны салбарт тасралтгүй 50 гурай жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргаж байгааг нь үнэлж Сэлэнгэ аймгийн Хүндэт иргэн, Түүхийн ухааны доктор, академич Өөлдийн Бавууг Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

-Төрийн захиргааны болон боловсролын байгууллагад тасралтгүй 40 гаруй жил үр бүтээлтэй ажиллаж, боловсрол соёлын байгууллагуудын материаллаг

баазыг бэхжүүлэх, өргөтгөх, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход идэвх зүтгэл гарган ажиллаж ирснийг нь үнэлж Мандал сумын ахмад настан Рэгжийбуугийн Нямсүрэнг МУ-ын Гавьяат багш цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

-Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Хушаат сумын Халиун буудай компанийн тракторчин Дэчингийн Пүрвээг Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

-Боловсролын байгууллагад тасралтгүй 50 гаруй жил ажиллаж ирээдүй өсвөр үеийнхнийг сурган хүмүүжүүлэх нэр хүндтэй үйлсэд хүч хөдөлмөрөө зориулсныг нь үнэлж Баянгол сумын ахмад настан Данзангийн Ишийг МУ-ын гавьяат багш цолоор шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав.

-Эрүүл мэндийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасныг нь үнэлж аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Жигжидсүрэнгийн Одыг “Эрүүлийг хамгаалахын Гавьяат ажилтан” цолоо шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа.

-Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг одон медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжлав. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 7, Алтан гадас одонгоор 23, Хөдөлмөрийн хүндэт медалиар 34 хүнийг шагнуулахаар санал уламжиллаа.

-Эрхэлсэн ажилдаа амжилт гарган, орон нутгийнхаа хөгжил дэвшилд оруулсан хувь нэмрийг нь үнэлж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Жигжээгийн Ганболд, Хушаат сумын ахмадын хорооны дарга Дашийн Оюун, Шаамар сумын Дулаанхаан тосгоны иргэн Ядамжавын Цэрэндолгор нарыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагналаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ сарын 21-ний өдөр Жавхлант сумын “Хурниад”, Ерөө сумын “Их Шинэстэй”ХХК-иудын хаврын тариалалтын явц байдалтай танилцаж, тариаланчидтай уулзлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Германий эрдэс, баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн газар, “United manajement consulting” LLC хамтран Сэлэнгэ аймгийг “Эрчимжсэн мал аж ахуй, Газар тариаланг хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болгон хөгжүүлэх боломж” сэдэвт онол үйлдвэрлэлийн Олон Улсын бага Хурлыг 5-р сарын 12-нд аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгууллаа. Хуралд ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн дарга, Улсын мал эмнэлэг үржлийн газрын мэргэжилтэн, ХААИС-ийн багш, эрдэмтэн докторууд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд нийт 400 гаруй төлөөлөгчид оролцож мал аж ахуйн чиглэлээр шинээр баталсан хууль тогтоомж, шийдвэр цаашид мал аж ахуйн талаар баримтлан ажиллах бодлого аймгийн бодлогыг танилцуулан зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмжийг сумдад хүргүүлсэн. Мөн энэ үеэр “Шилмэл мал” үзэсгэлэнг зохион байгуулж 10 сумын 8 аж ахуйн нэгж 13 иргэний шилмэл малыг оролцуулсан. Алатоу, Сэлэнгэ, Герефорд, Хар тарлан, Голшдэнь, Халимал, КЦТ, Хар, улаан ангус, лимузин зэрэг үүлдрийн үхэр, Ерөө, Хангай, Суффольк үүлдрийн хонь, Цэвэр эрлийз үүлдрийн адуу, Зөгий, Цацагт хяруул, Бүдэн, тахиа, галуу шувуу болон Монгол, Түвд банхар зэрэг нохойны үүлдрүүдийг үржүүлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, танилцуулгыг зөвлөгөөнд оролцогчдод болон ард иргэдэд сурталчилсан.

Аймгийн хэмжээнд нийт 174.1 мянган га талбайд тариалахаас энэ сарын 21-ний байдлаар тариалалт 58,9 хувьтай явагдаж байна. Үүнээс 84,5 мянган га-д улаанбуудай, 20 га-д арвай, 833 га-д овьёос, 14,4 мянган га-д рапс, 2,8 мянган га-д тэжээлийн ургамал, 1126 га-д төмс, 709,9 га-д хүнсний ногоо тариалсан мэдээтэй байна.

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг зохион байгуулах талаар сумдын Засаг дарга, холбогдох газруудад чиглэл өгч 5 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Аймгийн хэмжээнд 2379 иргэн, 298 аж ахуйн нэгж байгууллага ажиллаж, 17928 ширхэг мод тарьж, 267 өрх хашаандаа 2119 мод тарьсан байна.

Аугаа их эх орны дайны Ялалтын 72 жилийн ойг тохиолдуулан Алтанбулаг суманд байрлах Зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг энэ сарын 4-ний өдөр зохион байгууллаа. Хүндэтгэлийн арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг даргын орлогч болон ОХУ-аас Дархан-Уул аймагт суугаа Ерөнхий консул, Хиагтын аймгийн Засаг дарга, Орос, Монголын чөлөөлөх дайны ахмад дайчид, нутгийн ард иргэд оролцлоо. Түүхэнд тодоор тэмдэглэгдсэн энэхүү дайны ялалтыг авчрахад эхний өдрөөс эцсийн мөч хүртэл Монголчууд Оросын ард түмэнтэй сэтгэл нэг байж, “Хувьсгалт монгол” танкын цуваа, “Монгол ард” нисэх онгоцны эскадриль болон монгол морьд, сэтгэл санаа шингэсэн эд материалыг фронтод илгээж үнэтэй хувь нэмэр оруулж байсныг энэ өдөр нэхэн дурсцгааж, Алтанбулаг сумын сургуулийн сурагчид, “Сэлэнгийн долгио” чуулгын уран бүтээлчид, ХЦ-ийн 0243-р ангийн үлээвэр хөгжимчид ая дууны мэндчилгээ өргөлөө.

Онцгой байдлын талаар:

Эрүүл мэндийн байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамж”-ийн шалгалтын хүрээнд 28 объект, төлөвлөгөөт бус хяналт шалгалтад 30 байгууллага нийт 58 аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 296 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 44, мэдэгдэл 12, ажиллагаа зогсоох тогтоол 1, дүгнэлт 2-ийг үйлдэж хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 1 аж ахуйн нэгж, байгууллагыг 50000 төгрөгөөр торгож захиргааны арга хэмжээ ногдуулсан.

“Гэр хороолол-Усан хангамж” нэгдсэн арга хэмжээний удирдамж боловсруулан Онцгой байдлын хэлтсийн даргаар батлуулж ГТУА-19, 40 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнд танилцуулан гарын авлага, сэрэмжлүүлэг хуудас 400 ширхэгийг бэлтгэн 575 айл өрхөд үзлэг хийж, гал түймэр гарч болзошгүй 863 зөрчлийг илрүүлэн сэрэмжлүүлэг зөвлөмж өгч ажиллаа.

Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хамтарсан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад Д.Баасанбат Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн албаны мэргэжилтэн Н.Хуягтай хамтран 2017 оны 05 дугаар сарын 02-с 05 дугаар 04-ний өдрийг хүртэлх хугацаанд Хүдэр, Ерөө, Жавхланта зэрэг сумдын мэргэжлийн анги болон ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудад Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулж, ой, хээрийн түймрийн багаж зэвсэглэмжийн бэлтгэл, бэлэн байдлыг шалгаж мэргэжил арга зүйн туслалцаа зөвлөлгөөг газар дээр нь өгч ажиллаа,

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай, аймаг сумын Засаг дарын захирамж, Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулан ОБГ-ын газрын даргаар батлуулан Ерөө, Хүдэр, Бугант тосгоны ЗДТГ-аас “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил болон дайчилгааны захирамж, багаж, техник хэрэгсэл хүн, хүчний хуваарийг шалган зааварчилж ажиллаа.

“Орон сууцны гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлье” сэдэвт арга хэмжээний хүрээнд Сайхан сумын ЗДТГ, багийн Засаг дарга, нийгмийн ажилтан нартай хамтран Гал түймэр унтраах, аврах 61-р ангийн алба хаагчид нийтийн орон

сууцны 1-26-р байрны 256 айл өрхийн 732 ард иргэдэд урьдчилан сэргийлэх заавар зөвөлгөө өгч аюулгүй байдлыг хангууллаа.

Хяналт шалгалтын ажлын харьцуулалт

Үзүүлэлт	Үзлэг шалгалтанд хамрагдсан		Зөрчил		Бичсэн эрх зүйн бичиг баримт						Хянасан зураг төсөл
	Он	ААНБ	Айл өрх	Илрүүлсэн	Арилгуулсан	ЗБАШ	Мэдэгдэл	Танилцуулга	Дүгнэлт	Акт	
2016 оны 05-р сар	35	-	140	17	17	5	-	2	6	3	1
2017 оны 05-р сар	58	575	296	66	44	12	1	2	9	1	1
Өссөн Буурсан /хувиар/	+60	+100	+75.6	+74.2	+61.3	+58.2	+100	-	+33.3	-66.3	-

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо 60 хувиар, айл өрхийн тоо 100 хувиар, зөрчил дутагдлыг арилгахаар бичсэн албан шаардлага 74.2 хувиар, мэдэгдэл 58.2 хувиар, гал түймэр гарсан тухай акт 33.3 хувиар, тус тус өссөн байна.

2017 оны 05 дугаар сард 18 удаагийн объектын гал түймэр гарсанаас мэдээллээр 1, 3 гал түймрийг иргэд унтраан, 15 гал түймэр дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллаж унтраасан.

Гарсан 18 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 9 үйлдэж шийдвэрлэсэн. 7 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдэж материалыг хаасан бөгөөд 2 гал түймрийн хэрэг мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Гал түймрийн шалтгаан нөхцлийг судалж үзвэл цахилгааны техникийн гэмтлээс 1, цахилгаан ашиглалтын буруугаас 2, ил задгай асгасан үнс нурамнаас 8, машин техникийн гэмтэл ашиглалтын буруугаас 1, технологийн горим зөрчигдсөнөөс 1, шалтгаан тогтоодоогүй 3 бусад 2 удаа тохиолдсон.

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх талаар факс мэдээ 2-ыг сум орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэнээс гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр-2, сонинд-1 удаа мэдээ явуулсан.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

"Дэлхийн хэмжил зүйн өдөр"-ийг угтан Сүхбаатар сумын 12 жилийн 2-р сургуулийн 50 гаруй сурагчдад хэмжилзүйн анхан шатны мэдлэг олгох сургалт зохион байгууллаа.

Аймгийн МХГ-ын хэмжилзүйн байцаагчид, Газрын тосны хэрэг эрхлэх газрын Сэлэнгэ аймаг дахь төлөөлөгч, СХЗХ-ийн хэмжилзүйн лабораторийн улсын шалгагч нар хамтран газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг "НИК" ХХК, "МТ" ХХК, "Тэс петролеум" ХХК, "Шунхлай петролеум" ХХК, "Сод монгол групп" ХХК-ий

борлуулж буй бензин, дизель түлшний чанар, хэмжлийн үнэн зөв байдлыг үнэлэх зорилгоор Сүхбаатар, Шаамар суманд үйл ажиллагаа явуулж байгаа ШТС-уудын шатахуунаас дээж авч А-80, АИ-92 бензиний октаны тоог шинжилгээний болон моторын аргаар, дизель түлшний цетаны тоог шинжилгээний аргаар тодорхойлох хэмжилт шинжилгээг хийж, түгээгүүрийн шахалтыг мерникээр шалгах замаар хамтарсан шалгалтыг хийсэн.

Мөн Сайхан, Сант, Сүхбаатар, Баруунбүрэн, Ерөө сумын хүүхэд харах үйлчилгээний төвд “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015” стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажиллав.

Стандартчлал, хэмжил зүйн газраас зохион байгуулсан “Баталгаажуулалтын суурь асуудал, баталгаажуулалтын схемийн тухай” сургалтад хэлтсийн шинжээчид хамрагдсан.

Тайлант сард ээлжит баталгаажуулалтын ажлаар Сайхан, Баруунбүрэн, Баянгол, Мандал сум, Номгон, Түнхэл тосгонд ажиллаж, 29 хүнсний дэлгүүр, 13 минимаркет, 3 хүнсний мухлаг, 8 зоогийн газар, 4 кафе, 1 цайны газар, 1 зочид буудал, 1 сувилал, 4 караоке баар нийт 64 үйлчилгээний газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгож, стандартын шаардлага хангахгүй 1 үйлчилгээний газарт үл тохирлын мэдэгдэл өгч, Сүхбаатар сумын 2 аж ахуйн нэгжийн 2 нэрийн 2 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулан, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргасан.

Сүхбаатар сумын иргэн Дөлгөөний үйлдвэрлэж буй өндөгний хуймаг, өндөгтэй нарийн боовны хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлүүлж, аймгийн ХАҮТ-аас зураасан кодтой болоход нь арга зүйн заавар туслалцаа үзүүлж, “Бэлчир” цехийн үйлдвэрлэдэг халуун утлагат загас, Орхонтуул сумын “Замбал зоог” ХХК-ий үйлдвэрлэж буй талх, хэрчсэн гуриланд дотоодын бүтээгдэхүүний “Тохирлын гэрчилгээ” тус тус олголоо.

Стандартын салбар сангаас 4 аж ахуй нэгж, байгууллага, иргэний 4 нэрийн 8 стандартын захиалга авч, 2 аж ахуй нэгж байгууллага иргэнд 2 нэрийн 2 стандартын борлуулалт хийж, 2 аж ахуй нэгж байгууллага, иргэнд 2 нэрийн 2 стандартаар ханган, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн.

“Урсгал ус” ХХК-ний хэмжих хэрэгслийн суурилуулалт, засвар эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлтийг дүгнэж, тайланг СХГ-ын хэмжилзүйн хүрээлэнд хүргүүллээ.

Механик хэмжлийн лабораториос Сайхан, Баруунбүрэн, Дулаанхан, Баянгол, Мандал сумдад ээлжит баталгаажуулалтаар ажиллаж худалдаа, үйлчилгээ, төрийн байгууллагын 133 хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулалтад хамруулсан.

Мөн цахилгааны 16 нэг фазын тоолуурыг шалган баталгаажуулсан. Мөн цахилгааны СЕ101, ЦЭ6803В загварын тоолуурын талаарх судалгааг авч, СХГ-т хүргүүлж, Сүхбаатар сумын эмнэх баг, Мандал сумын нэгдсэн эмнэлэгийн эмч нарын ашиглаж байгаа 33 цусны даралтын аппаратыг шалгаснаас 31 шаардлага хангасан тул баталгаажуулалтын гэрчилгээ олгогдсон.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын 2017 оны төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотойгоор аймгийн тодотгосон төсвийн нийт, орлого зарлагыг 64,132.3 сая төгрөгөөр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 21 дүгээр тогтоолоор батлуулан төсвийн хэрэгжилтийг хангахаар Засаг даргын А/423 тоот захирамжаар төсвийн сар, улирлын хуваарийг шинэчлэн баталж хэрэгжүүлж эхлээд байна.

Жил бүр уламжлан болгон зохион байгуулдаг “Татвар төлөгчдийн өдөр”-ийг энэ сарын 08-нд арга хэмжээ зохион байгуулсан бөгөөд “Би – ирээдүйн татвар төлөгч” сэдэвт хичээлийг аймгийн хэмжээнд зохион байгуулж 17892 сурагч хүүхдүүдийг хамрууллаа. Мөн тус өдрөөр шилдэг татвар төлөгч 3 аж ахуйн нэгж байгууллага, шилдэг 3 татвар төлөгч иргэдийг шагнаж урамшууллаа.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2017 оны 4-р сарын танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг www.selenge.nso.mn хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	5,068,069.1	8,584,767.2	169.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	3,898,308.5	3,876,739.5	99.4
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	25,971,678.7	22,615,665.0	87.1
	Үүнээс: ТЗШ байгууллагын зарлага			
	- Аймгийн төсвийн зарлагын дүн	6,598,809.7	5,710,142.6	86.5
	- Аймгийн ОНХСангийн зарцуулалт	197,190.5	112,026.4	56.8
	- Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	160,000.0	-	-
	- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	-	-	-
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	451,763.8	451,763.8	100.0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	1,450,000.0	1,450,000.0	100.0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	15,987,942.8	15,987,942.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	7,903,505.9	7,903,505.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	4,208,987.4	4,208,987.4	100.0
	- Соёлын байгууллага	1,149,328.8	1,149,328.8	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	434,641.0	434,641.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,088,236.8	2,088,236.8	100.0
	- Хүүхдийн байгууллага	76,900.7	76,900.7	100.0
	- Газрын харилцааны байгууллага	126,342.2	126,342.2	100.0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	15,987,942.8	15,987,942.8	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	7,903,505.9	7,903,505.9	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	4,208,987.4	4,208,987.4	100.0
	- Соёлын байгууллага	1,149,328.8	1,149,328.8	100.0
	- Биеийн тамир спортын байгууллага	434,641.0	434,641.0	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,088,236.8	2,088,236.8	100.0
	- Хүүхдийн байгууллага	76,900.7	76,900.7	100.0
	- Газрын харилцааны байгууллага	126,342.2	126,342.2	100.0
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	1,157,720.8	1,157,720.8	100.0
8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	531,667.1	375,388.9	70.6
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	277,856.5	277,856.5	100.0
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	187,800.0	187,800.0	100.0
11	Тусгай сангуудын зарлага	-	-	-

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2017 III - сар	2017 IV- сар	<u>2017-III</u> <u>2017-IV</u> /төгрөгөөр/
-------------------------------------	-------------------	-----------------	--

1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1'200	1'200	
	Талх /орон нутгийн, ш/	1'100	1'100	
	Нарийн боов /кг/	2'100	2'100	
	Будаа /кг/	2'400	2'400	
	Элсэн чихэр /кг/	2'200	2'300	+100
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	5'500	6'000	+500
	Үхрийн мах /кг/	7'500	8'000	+500
	Адууны мах /кг/	6'000	6'500	+500
	Ямааны мах /кг/	5'000	5'500	+500
	Дотор мах, цувдай /цусгүй/	3'000	3'000	
	Хиам /чанасан, кг/	10'000	10'000	
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1'700	1'300	-400
	Сүү / савласан, л/	2'500	2'500	
	Тараг /задгай, л/	1'800	1'800	
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	13'000	13'000	
	Айраг /л/	3'500	3'500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4'000	4'000	
	Өндөг /ш/	350	320	-30
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3'800	3'800	
	Өөхөн тос /кг/	1'800	1'800	
	Шар тос /кг/	10'000	10'000	
	Масло /задгай, кг/	4'000	4'000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	700	700	
	Лууван /кг/	700	500	-200
	Манжин /кг/	1'000	1'000	
	Байцаа /кг/	2'000	1'500	-500
	Сонгино /кг/	3'000	3'000	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3'300	3'300	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630gr/	2'500	2'500	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1'480	1'480	
	Бензин А - 92	1'630	1'630	
	Дизелийн түлш	1'720	1'720	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

“Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/51, А/69 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын 2017 оны А/244 дугаар захирамжаар “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-г байгуулж, хорооны гишүүдэд хүргүүлээд байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны 4 дүгээр сард 250 холбогдогчтой, 381.2 сая төгрөгийн хохиролтой, 220 гэмт хэрэг бүртгэгдэж, 48 хэргээр буюу 17.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сум болон 7-р баг, Хушаат, Орхон сумдад 16.7-80.0 хувиар, Хүдэр суманд 2.5 дахин өсч, Сүхбаатар сумын 2, 3, 4, 5, 8-р баг, Шаамар, Ерөө, Бугант тосгон, Жавхлант, Цагааннуур, Мандал, Сайхан, Сант, Орхонтуул, Баруунбүрэн сумдад 11.3-83.3 хувиар, тус тус буурч, Сүхбаатар сумын 1, 6-р баг, Алтанбулаг, Дулаанхаан тосгон, Зүүнбүрэн, Түшиг, Баянгол сумдад өнгөрсөн оны мөн үетэй адил түвшинд байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 5 дугаар сард 207 төрөлт, 58 гэрлэлт, 9 гэрлэлт цуцлалт, 45 нас баралт бүртгэгдэж, 744 иргэнд цахим үнэмлэх, 59 иргэнд үндэсний энгийн гадаад паспорт, хил нэвтрэх үнэмлэх 4928 ширхэг олгож, аймаг, хотруу шилжин явсан 70, шилжин ирсэн 110, сум дүүрэгт шилжин ирсэн 42, сум дүүрэгт шилжин явсан 25, баг хооронд шилжин ирсэн 89, баг хооронд шилжин явсан 98 шилжилт хөдөлгөөн бүртгэгдээд байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 759 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 1084 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамжийн 306420 төгрөг, үйлчилгээний хураамжийн 15.762.736 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварт 12.303.309 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

2.Архивын талаар

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн дөрөвдүгээр үе шатыг 2017-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг сумдын Засаг дарга, газар хэлтэс, албадын дарга нарт хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн.

2017 онд Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу Баянгол, Хүдэр, Жавхлант сумдын ЗДТГ, аймгийн Эрүүл мэндийн газар, Мандал сумын “Цант орхон” ХХК-д байнга хадгалах баримтаа цаасан буюу цахим хэлбэрээр хүлээлгэн өгөх тухай албан тоотыг хүргүүлж Жавхлант сумын ЗДТГ-ын 2006-2010 оны 19 хн, “Спирт бал бурам” ХХК-ний 1978, 1985, 1992-1998 оны 10 хн, Мандал сумын “Цант-Орхон” ХХК-ний 1999-2012 оны 55 хн-ийг жагсаалтын дагуу хүлээн авч хөмрөгийн хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлж, сумдын болон газар хэлтэс агентлагуудын архив, бичиг хэргийн ажилтнуудад зориулсан “Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах”, Төрийн архивын сан хөмрөгийг цахим буюу цаасан суурьтай баримтаар нөхөн бүрдүүлэх” тухай зөвлөмжийг хүргүүлсэн.

Аймгийн Ардын дуу бүжгийн “Сэлэнгийн долгио чуулга”-ын 1962-1976 оны 13 хадгаламжийн нэгжид нягтлан шалгалтын ажлыг хийж 6 хадгаламжийг нэгжид ЭШТБ-ын ажлыг, Мандал сумын “Спирт бал бурам” ХХК, “Цант-Орхон” ХХК, Баянгол, Жавхлант сумын Засаг даргын Тамгын газар зэрэг 4 хөмрөгийн 99 хадгаламжийн нэгжийн 10145 хуудас баримтыг скайнердаж мастер хувь үүсгэсэн.

Баримтыг цахимд шилжүүлэх төлөвлөгөөний дагуу Ерөөгийн мод бэлтгэлийн аж ахуйн 1971-1979 9 хадгаламжийн нэгж, Эрүүл мэндийн газрын 1970-1981 оны 22 хадгаламжийн нэгж, Сүхбаатар хотын Ойн техник мэргэжлийн сургуулийн 1985 оны 1 хадгаламжийн нэгж, аймгийн Боловсрол, соёлын газрын 1982 оны 2 хадгаламжийн нэгж, Номгон тосгоны 8 дугаар цэцэрлэгийн 34 хадгаламжийн нэгж, Номгон тосгоны Соёлын төвийн 8 хадгаламжийн нэгж, Номгон Эрүүл мэндийн төвийн 19 хадгаламжийн нэгж, нийт 7 хөмрөгийн 95 хадгаламжийн нэгж, 8004 хуудасны мэдээллийн агуулгыг уншиж заалт-6777, хүний нэр-20506, байгууллагын нэр-1609, газар зүйн нэр-8351-ийг АМС программд шивж, эх баримттай нь холбох ажлыг хийлээ.

Иргэн Д.Ганхуягийн өргөдлийн дагуу холбогдох лавлагаа гаргаж өгөх тухай албан тоотыг Архивын ерөнхий газрын дарга Д.Хоролдамба, Үндэсний төв архивын дарга Б.Эрдэнэбадрах, Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн Архивын тасагт, Моннис майнинг экьюпмент ХХК-ний хүсэлтийн дагуу архивын тодорхойлолт, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны

шүүхээс ирүүлсэн нотлох баримт ирүүлэх тухай албан тоотын хариуг тус тус хүргүүлсэн.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар 196-г гаргаж, үүнээс цахим хэлбэрээр 139, цаасан суурьтай баримтаас 17, мастер хувиас 40 тус тус гаргаж, үйлчилгээ үзүүллээ.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

“Улсын төрөлжсөн олимпиад зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу аймгийн аварга багш, сурагчдыг шалгаруулан улсын олимпиадад оролцуулж, 2 багш 2 сурагчид байр эзэлж, 1 сурагч ШУТИС-д 2 жил дараалан хөнгөлөлттэй суралцах эрхээр шагнагдлаа.

БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газрын удирдлагын төлөөлөл 05 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зочилж, аймгийн Засаг даргатай уулзалт зохион байгуулан Сүхбаатар сумын бүрэн дунд 2 дугаар сургууль, 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцан БСУГ-тай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа.

5,9,12 дугаар анги төгсөгчдөөс авах улсын шалгалтыг 05 дугаар сарын 22-30-ны өдрүүдэд зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. “Үндэсний хэл бичиг-тусгаар тогтнолын баталгаа” уриан дор сургууль бүр багш, сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргаж, сурагчдын дунд зөв сайхан бичих, хурдан унших, танин мэдэхүйг хөгжүүлэх уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж, бүх сурагчид хамрагдлаа.

2017 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд дунд, ахлах ангийн 34 сургалтын менежерүүдийн туршлага судлах болон чадваржуулах сургалтыг зохион байгуулж, Улаанбаатар хотын 48, 84 дүгээр сургууль, Багшийн хөгжлийн ордоны үйл ажиллагаатай танилцлаа.

17 сумдын соёлын төвийн номын санчдыг Улаанбаатар хотын Төв номын сан, Хүүхдийн номын сан, Техникийн их сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлагаа хуваалцах арга хэмжээнд хамрууллаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хүний нөөц, хувилбарт сургалт, цэцэрлэгийн камержуулалт, цэцэрлэгийн барилга байгууламж, хөгжмийн багш нарын судалгаа зэрэг нийт 5 төрлийн судалгааг гаргаж БСШУСЯ-нд хүргүүлээ.

“Сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн” зохион байгуулж, нийт 120 багш оролцов. Хичээл зааж, хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулсан багш нарт БАТЛАМЖ”, “Зөвлөх” мэргэжлийн зэрэгтэй 6 багшид “ТАЛАРХАЛ” гардуулав.

Сургуулийн бүх сургуулийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад сургуулийн насны хүүхдийн 71,5%, цэцэрлэгийн насны хүүхдийн 50,5% өвчлөлттэй гарч, хүүхдүүдийг зуны амралтаар нь эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх талаар сургууль, цэцэрлэгийн захиргаанд үүрэг даалгавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

БСШУСЯ, БОАЖЯ, ШХБ, БОМСТ-оос 2017 оны 05-р сарын 05-нд хамтран зохион байгуулсан Монгол улсын “Эко сургууль”-ийн гэрэгээ гардуулах ёслолд Баянгол, Хушаат Мандал сумын 1, 3-р сургуулиуд оролцож, хүрэл гэрэгээ гардан авлаа.

ЭЕШ өгөх 1484 шалгуулагчийн баазыг Боловсролын үнэлгээний төвд хүлээлгэн өглөө.

БТТА, АБТА залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч Ц.Төмөрхуягийн нэрэмжит биеийн тамирын хичээл олимпиадыг зохион байгуулж, 17 сумдын сургуулийн биеийн тамирын 14 багш, 80 гаруй тамирчид оролцлоо.

Сүхбаатар сумын бүрэн дунд 5-р сургуулийн нэрэмжит аваргын гараа өсвөрийн үндэсний бөхийн 11 дэх удаагийн тэмцээнийг 2017 оны 05-р сарын 05-наас-09-ны өдрүүдэд зохион байгуулж, 4 насны ангилалд 144 бөхчүүд уран мэхийг уралдуулан барилдлаа.

Сүхбаатар суманд 2017 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр үндэсний шагайн харвааны тэмцээнийг Монгол Улсын спортын мастер, Үлэмж дархан мэргэн Хайдавын Баатаржавын нэрэмжит болгон зохион байгуулж, Сэлэнгэ, Өвөрхангай, оролцсон. Мөн Цагдаагийн газрын нэрэмжит өсвөрийн аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг 04 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулж, 15 сумдын 39 багийн 250 тамирчин оролцон Бүгд Найрамдах Солонгос Улсын сагсан бөмбөгийн залуучуудын шигшээ баг Сэлэнгэ аймгийн залуучуудын шигшээ багтай нөхөрсөг тоглолт хийлээ.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2017 оны 04 дүгээр сарын байдлаар бүртгэлгүй ажилгүй иргэд 847 байсан бол 456 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 83 ажлын байранд 72 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 80 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1151 болсон байна. 6 сумын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэдтэй уулзалт зохион байгуулан, төсөл хэрэгжүүлэх боломжинд судалгаа хийж, ядуурлаас гарах өрхүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулах талаар сумдын хамтарсан багийн гишүүд болон амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаа.

2017-2020 онд Сэлэнгэ аймагт ажлын байрыг нэмэгдүүлэх төслийн хүрээнд Европын холбооны төлөөлөгчидтэй хамтран ажиллах талаар уулзалт ярилцлага, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулж, 40 гаруй хүн оролцлоо.

Нийгмийн халамжийн сангаас 05 дугаар сарын байдлаар 25633 иргэнд 3.761.610.904 төгрөгийг олгоод байна.

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2541 иргэнд 1.252.878.990 төгрөг
- Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж 1250 иргэнд 294.235.770 төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 1159 иргэнд 232.944.010 төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 2540 иргэнд 124.212.990 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгож буй тусламж хөнгөлөлт 164 иргэнд 32.466.024 төгрөг
- Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 2573 эхэд 315.141.350 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлэх тусламж хөнгөлөлт 56 иргэнд 28.466.670 төгрөг
- Эхийн алдар одонтой эхчүүдийн хөнгөлөлт тусламжинд 7821 иргэнд 1.050.120.000 төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 3717 иргэнд 199.732.100 төгрөг
- Насны хишиг 3937 иргэнд 311.830.000 төгрөг

3.Эрүүл мэндийн талаар

2017 оны 4-р сарын байдлаар нийт хүн амаас артерийн гипертензи эрт илрүүлэгт 13,3%, чихрийн шижин-9,3%, хөх, умайн хүзүү-19,4%, элэгний үзлэг-9,5% нь хамрагдсан байна. Жирэмсний хяналтанд эхний 3 сартай 161 эх буюу 85,6%, 4-6 сартай 25 эх буюу 13,2%, хожуу хяналтанд 2 эх буюу 1,06%-нь байна.

Зудад өртсөн сумын Эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнуудыг чадавхижуулан, сургагч багшаар бэлтгэж, гамшгийн үед хоол тэжээлийн байдалд үнэлгээ хийх арга зүй эзэмшүүлэх сургалтыг 2017 оны 04 сарын 24-26-нд зохион байгуулж, Сүхбаатар, Мандал, Алтанбулаг, Баянгол, Ерөө, Орхонтуул, Хүдэр, Хушаат, Түшиг, Шаамар, Цагааннуур, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Жавхлант зэрэг 14 сумдын 31 эмч ажилтнуудыг хамруулж, Олон улсын сувилагчдын баярын өдрөөр бүх сум тосгодын сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн дунд мэргэжил, урлаг спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулж, 8 багийн 80 гаруй тамирчид оролцсон.

2017 оны 1-р ээлжийн цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгт нийт 1346 цэргийн насны залуучууд хамрагдсан.

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж байгаа төвүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь аргуулах арга хэмжээ авч, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлээ. “Монголын ураг, удам, уламжлалын холбоо” ТББ-тай хамтран Угийн бичиг хөтлөх уламжлал арга зүй, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, ёс уламжлалаа үр хүүхдэдээ өвлүүлэх, иргэд айл өрх бүрийг угийн бичиг хөтөлж сургах хэлэлцүүлэг зохион байгуулж, 17 сумд, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 40 хүн оролцсон.

“Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь” сургалтыг Зүүнбүрэн, Шаамар, Дулаанхан, Алтанбулаг, Түшиг сумдуудад зохион байгуулж, 42 гишүүд оролцов.

“Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” олон нийтийн санаачилга өрнүүлэх ажлын хүрээнд “Би хүүхэд хамгааллын бодлого баримтлагч багш” уралдааны удирдамж, чиглэлийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран гаргаж ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлээд байна.

Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг эхний хагас жилийн байдлаар 3 үзүүлэлтээр гарган хүүхдийн тоо бүртгэл судалгаатай болсон. Мөн хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 11 дуудлагад хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлж ажилласан.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Шилдэг гэр бүл” шалгаруулах арга хэмжээг зохион байгууллаа. Нийт 1078 гэр бүл оролцож, 51 гэр бүлийг шалгаруулан урамшууллаа.

Монголын Скаутын холбоотой хамтран Ази номхон далайн бүс нутгийн 31 дүгээр Жембори болохтой холбогдуулан Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 8 сургуулийн өсвөр насны хүүхдүүдийн дунд сургалт мэдээллийг өгч нийт 800 гаруй хүүхэд хамрагдлаа.

“Залууст боломж” аймгийн дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Дулаанхаан тосгон, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг, Түшиг сумдын нийт 90 гаруй залуучуудын дунд орон нутгийн залуучуудын өмнө тулгамдаж буй асуудал, цаашид хийх арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Нийгмийн даатгалын сангуудад 11231991,3 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 11015068,81 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 98,06 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 15550 тэтгэвэр авагчдад 22360,5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 2731 хүнд 821,08 сая төгрөгийг ХЧТА, ЖА, оршуулгын тэтгэмжид, Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлэг, эмийн сангуудад 1832,02 сая төгрөгийн зардлыг, ажилгүйдлийн даатгалын сангаас 229 даатгуулагчид 311,79 сая төгрөгийг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 271 даатгуулагчид 453,49 сая төгрөгийн тэтгэвэр, ҮО-ийн тэтгэмж, сувилалын зардалд олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа болон нөхөн даатгалын лавлагааг 69 иргэд, даатгуулагчид гарган үйлчилж, “Нийгмийн даатгалын хууль”-ийн сурталчилгааг Сүхбаатар сумын хэмжээнд нийт 15 аж ахуй нэгжийн 334 даатгуулагчдад сургалт явуулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад “Эрүүл мэндийн даатгалын тухай ойлголт, “Сурагч таны эрүүл мэндэд даатгалын байгууллагын оролцоо” хувь нэмэр, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг сурагчдад таниулах ажлыг зохион байгуулж, 500 сурагч, 64 оюутан хамрагдлаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар 475 хүн орсоноос 19 хүнийг цуцалж, 48 хүн шинээр тогтоолгосон, 408 хүн актаа сунгуулсан.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 7 байгууллагын 2169957 төгрөгийн өрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар барагдуулж, шүүхийн эвлэрлүүлэн зуучлалаар нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой маргааны 10007037 төгрөгт эвлэрлийн гэрээ байгуулан шүүгчийн захирамжаар баталгаажуулж, 3 байгууллагын 8086000 төгрөгийн өрийг барагдуулсан байна.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Мах, сүүний анхдугаар аян”-ыг аймгийн сумын хэмжээнд зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гарч, 37 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, “Жаргалан сэтгүүл”, “Zarig.mn видео сайт”-тай хамтран “Эрүүл амьдрал экспо” үзэсгэлэн худалдааг Улаанбаатар хотын “Мишээл экспо”-д 05 дугаар сарын 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулж, Мандал, Сүхбаатар, Баянгол, Түшиг, Сайхан, Шаамар сумдын 8 аж ахуйн нэгж, иргэд 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнтэй оролцож 12 сая төгрөгийн борлуулалт хийж, ТҮ5, Монголын Үндэсний олон нийтийн телевизээр сурталчилан ажиллалаа.

“Монголд бид үйлдвэрлэв” төрийн бус байгууллагаас санаачлан зохион байгуулж “Уран үйлчин” улсын анхдугаар уралдааныг “Сэлэнгийн уран бүсгүйчүүл” төрийн бус байгууллагатай хамтран Сүхбаатар суманд зохион байгуулж, 5 сумын 42 оёдолчид оролцлоо.

2017 онд нийт 733364 эх мал төллөхөөс 05 дугаар сарын 20-ны байдлаар 485877 мал төллөсөнөөс ингэ 44, гүү 11692, үнээ 54220, хонь 260358, ямаа 159563 төллөөд байна. Төлийн хорогдол 11584 байгаагаас ботго 3, унага 121, тугал 807, хурга 6583, ишиг 4070 хорогдсон дүн мэдээтэй байна. Мал төллөлт 66,3 хувьтай төл бойжилт 97.4 хувьтай байна. Өнөөдрийн байдлаар 42461 толгой том мал зүй бусаар хорогдсоноос адуу 959, үхэр 5883, хонь 21909, ямаа 13710 байна. Үүнээс хээлтэгч 15692, өвчнөөр 3807 бусад нь зүй бусаар хорогдсон мэдээтэй байна. Малчид хаваржаандаа бууж дуусаад байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/215 тоот захирамжаар аймгийн хэмжээнд нийт 47800 малд үзлэг ангилалт явуулахаас 37800 бог мал, 10000 бод малд үзлэг ангилалт явуулж анги чанар тогтоохоор ажиллаж байна. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулах тухай аймгийн Засаг даргын захирамжийн дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Дотрийн халдварт хордлого, Шөвөг яр, гахайн мялзан, дуут хавдар, галзуу, хонины цэцэг өвчний нийт 25.067 сая төгрөгийн вакцин тарилгыг хүлээн авч хуваарийн дагуу сумдын Мал эмнэлэг, үржлийн нэгжүүдэд олгосон.

Алтанбулаг, Зүүнбүрэн, Түшиг, Шаамар, Цагааннуур зэрэг сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 65 эмгэгт дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг маягтын дагуу гаргуулан авч холбогдох мал эмнэлгийн нэгж болон иргэдэд өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч ирлээгүй. Ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар сумаас 48 адуунд нийлүүлгийн өвчин, ям, адууны халдварт цус багадах өвчин, Сант сумын бух-22, үнээ- 131, нийт 153 дээжинд бруцеллэз, лейкоз, сүрьеэ нийт давхардсан тоогоор 459 дээжинд шижилгээ хийж эрүүл болохыг баталгаажуулж хариуг олгосон.

Худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаа мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний Адууны махны 4 дээж, 508 кг, үхрийн махны 48 дээж 696 кг, хонины махны 109 дээж 2398 кг, гахай 4 дээж 360 кг, сүүний 140 дээж 4200 л, дайвар 1 дээж 50кг, өндөгний 180 дээж 3600 ш дээжинд тус тус МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулалж гэрчилгээ олгов.

JICA JAICAF-н "Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх" төсөл, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын зөгийчид болон малын эмч нар оролцож зөгийний өвчин, тухайн өвчинд эмийн бодисыг хэрхэн зөв зохистой хэрэглэх, тэдэнд зөгийн өвчний бүртгэл хэрхэн хийх, зөгийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, зөгийний өвчин гарсан үед малын эмчийн үүрэг оролцоо, шаардлага хангасан эмийн

зохистой хэрэглээг бий болгох, ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зөгийн аж ахуйн эрсдлийг багасгаж, үр ашгыг нэмэгдүүлэх ач холбогдолтой болох талаар мэдээлэл өгч мөн зөгийн аж ахуйг хариуцсан малын эмчийн анхаарах зүйлс, зөгийчид бидний эрхэмлэх зүйлс гэсэн 2 төрлийн ухуулга сурталчилгааны материал бэлтгэн тараасан.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Тайлант сард шинээр газар өмчилж авсан 15, газар эзэмших эрхээ баталгаажуулсан 3, худалдах худалдан гэрээгээр өмчлөх эрхээ шилжүүлсэн 8, өмчилсөн газраа бэлэглэсэн 2 иргэнийг Land manager 2 программд бүртгэн газар нэгж талбарын хувийн хэрэг үүсгэн баяжилт хийж Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн.

2.Байгаль орчны талаар:

Сэлэнгэ-Бэлчирийн бүсийн сум дундын Ойн ангитай хамтран Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдэд “Байгаль орчны салбарын салбарын хууль тогтоомжийн шинэчлэл, хэрэгжиж буй өнөөгийн байдал, ”Төрөөс ойн талаар баримтлах бодлого”, Ойн тухай хуулийн хэрэгжилт, ойн хөнөөлт шавжийн тухай, ойжуулалт нөхөн сэргээлтийн тухай, ойгоос мод бэлтгэх журмын тухай, Байгаль орчны салбарт хийгдсэн ажлууд” зэрэг сэдвүүдээр сургалт, семинар,уулзалтыг Шаамар, Түшиг, Зүүнбүрэн сумдад зохион байгууллаа. Шаамар сумын ойнсанг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийн төлөөлөл- хүн, Түшиг сумын 23 нөхөрлөлийн төлөөлөл- хүн, Зүүнбүрэн сумын 13 нөхөрлөлийн хүн оролцсон.

“Үрийн генетикийн” төслийн багийнхантай хийсэн уулзалтанд Ойн албаны мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж санал бодлоо солилцлоо. Үрийн аж ахуйн тулгамдаж буй асуудал, цаашид ямар сэдвээр сургалт, семинар авах зэрэг санал асуулгыг сумын болон сум дундын Ойн анги, ойн мэргэжлийн байгууллагаас авч нэгтэн төслийн багт хүргүүллээ.

“Ойн мэргэжлийн байгууллагуудыг чадавхжуулах нь” сэдэвт сургалт, семинарыг аймагт үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн 70 гаруй байгууллагыг хамруулан зохион байгууллаа. Уг сургалт семинараар “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”, ойн мэргэжлийн байгууллагууд улсын аттестачлалд хэрхэн бэлтгэх талаар болон ойгоос мод бэлтгэхэд анхаарах зарим асуудлууд, мод бэлтгэсэн талбайдаа өөрийн хөрөнгөөр ойжуулалт ойн нөхөн сэргээлт хийх талаар, ойн хөнөөлт шавжийн хэрхэн таних зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийлээ. Уг сургалт семинарт Магадлан итгэмтжлэлийн талаар мэдээлэлийг Магадлан итгэмжлэлийг Монгол оронд хэрэгжүүлж буй байгууллагын тэргүүн, гүйцэтгэх захирал, магадлан итгэмжлэгдсэн шинжээчид мэдээлэл хийснээс гадна магадлан итгэмжлэгдсэн “Сэлэнгэ Бугант” ХХК-ийн захирал магадлан итгэмжлэл авсан туршлага, алдаа оноо, сургамжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өглөө.

Мөн Сүхбаатар, Мандал сумдын агаарын болон орчны бохирдлыг бууруулах ерөнхий төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэгийг зохион байгуулж иргэд, багийн Засаг нар нийт 43 хүн оролцов.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум:

Сумын хэмжээнд байгаль орчны бохирдол, хүн, мал амьтны халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон төр төсвийн нийт 21 ажилтны бүрэлдэхүүнтэй малын сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулж, 3200 гаруй хорогдсон малын сэг зэмийг журмын дагуу булж устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийлээ.

Хонины цэцэг өвчний урьдчилан сэргийлэх тарилгыг 5-р сарын 19-өөс эхлүүлэн сумын нийт сонин сүрэгт хийж байгаа ба 10 гаруй мянган толгой хонийг вакцинжуулсан.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хууль бус ан, хулгайн модтой тэмцэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газар, ойн санг гэрээгээр эзэмшигчдийн төлөөлөл, сумын байгаль орчны тасгийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэй “Хяналтын цэг” ажиллаж байна. Тайлант сард эргүүл шалгалтанд нийт 10 удаа шалгалт хийж Ойн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Японы хөрөнгө оруулалтаар “Шаравхтайн булан”-д 25 га газарт ойжуулалт хийсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Бүх нитээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд 1512 ширхэг мод, бут сөөг тарьлаа.

Сумын ногоочдын уулзалтыг энэ сарын 4-ний өдөр хийж, ногоочдын бүлийг байгуулж холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгсөн.

Сумын Засаг даргын ивээл дор “Медалиа зүүцгээе” хүндэтгэлийн арга хэмжээг 3 дахь жилдээ “Дэлхийн зөн Монгол” ОУ-ын байгууллага, ХААН банкны салбар, “Пандалин хийд ивээн тэтгэж зохион байгуулж, 2016-2017 оны хичээлийн жилд амжилт гаргасан 71 сурагчийг алдаршууллаа.

Олон Улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Шилдэг гэр бүл-2017” арга хэмжээг зохион байгуулж, шилдэг төрийн түшээ гэр бүл, өнөрх бүл, тариаланч гэр бүл, бизнес эрхлэгч гэр бүл, залуу малчин гэр бүл тодруулж алдаршуулах арга хэмжээ авсан.

Аугаа их эх орны дайны ялалтын 72 жилийн ойг тохиолдуулан тус суманд байрлах Зөвлөлтийн дайжчдын хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмжээ оролцож, сумын сургуулийн сурагчид ая дууны мэндчилгээ өргөлөө.

Ерөө сум:

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг энэ сарын 17-ны өдөр зохион байгуулж, сумын ЗДТГ-ын гадаа талбайд сургууль, цэцэрлэг, соёлын төв, цаг уур, эмнэлэг гэсэн төсвийн байгууллагын албан хаагчид, “БТЕГ” ХХК, Тавин ус өртөө, ЗДТГ-ын ажилчид хамтран “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийн нээлтийн арга хэмжээнд оролцлоо. Сумын хэмжээнд 130 модыг тарьж, нөхөн тарилт хийлээ.

2017 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Сумын нэгдсэн хогийн цэгийн ойр орчмын хийсэж тарсан хогийг түүх ажлыг зохион байгууллаа. Уг ажилд сумын ЗДТГ, Соёлын төв, Цаг уур, Нарлаг цэцэрлэг, Эрүүл мэндийн төв зэрэг байгууллагын 52 албан хаагчид ажиллалалаа.

Мал амьтныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүн малын аюулгүй байдлыг хамгаалах үүднээс Засаг даргын захирамжийн ажлын хэсэг байгуулагдаж сумын хэмжээнд байгаа эзэнгүй золбин нохой устгах ажлыг зохион байгууллаа. Нохой устгалын мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн ба 2017 оны 05-р сарын 15-аас 22-ны өдрүүдэд зохион байгуулан явууллаа. Нохой устгалын ажлыг сумын 1, 2-р багийн нутаг дэвсгэрт хийж, 203 золбин нохойг устгаж, хогийн цэг дээр 10м³ –тэй 2 нүх ухаж бэлтгэн сэг зэмийг булж ариутгаж халдваргүйжүүлсэн.

2017 оны 05-р сарын 18, 19-ний өдөр жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Ерөө бүсийн төрийн албан хаагчдын урлаг, спортын наадам 6 дахь жилдээ тус суманд амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 100 гаруй төрийн албан хаагчид аваалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдөж, спортын тэмцээний төрөлд нийт дүнгээр Ерөө сум 1-р байр, Хүдэр сум 2 байр, Урлагийн төрлөөр, Ерөө сум 1-р байр, Хүдэр сум 2 байранд тус тус шалгарч шилжин явах цом эзэд боллоо.

5-р сарын 10-ны өдөр “Ахмадын дуулах өдөр” дуун цэнгүүний арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд арга хэмжээний үеэр татварын байцаагч, нийгмийн ажилтнууд 12 ахмадад имэйл хаяг нээх, гар утсанд апплейкшн суулгах, ebarimt.mn –д нэвтрэх нэр, нууц үгийг олгож үйлчиллээ.

Татвар төлөгчдийн татвар төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэйгээр ханган биелүүлж байгаа шилдэг татвар төлөгчийг

олон нийтэд таниулах, сурталчилах, татвар төлөгчдөд талархал илэрхийлэх, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгын дор Татвар төлөгчдийн өдрүүдийг “Эх орныхоо хөгжлийг бүтээгч эрхэм татвар төлөгч танд баярлалаа” уриатайгаар 05 сарын 04-аас 05 сарын 12-ны хооронд батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, татвар төлөгчдийн хуулийн мэдлэгийг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх, цогц мэдээллээр хангах, мэдээллийг олж авах нөхцөл бололцоог хангах зорилттойгоор тэмдэглэн өнгөрүүллээ. Мөн “Татвар төлөгч танд зөвлөө” нэрийн дор НӨАТ төлөгч Мянган цагаан туг ХХК, Есэн эрдэнэ оргил ХХК, Хөдөөгийн баясгалан ХХК зэрэг 3 аж ахуйн нэгжийн ажлын байран дээр очиж НӨАТ-ын тайлан илгээх, худалдан авалт, борлуулалтын талаарх мэдээлэл авах зэрэг асуудлаар зөвлөгөө өгсөн. Аймгийн төвд зохион байгуулагдсан зөвлөгөөнд “Ачит-Оргил” ХХК, “Төгөлдөр хангай” ХХК, “Тэнүүн хүслэн” ХХК зэрэг 3 аж ахуйн нэгжийг, “Итгэл төгс заяа” ХХК, “Тэнгэрлэг Ерөө” ХХК, “ХБЛГ” хоршоо, “Дэвших Ерөө” хоршоо, “Сондор Ерөө” ХХК, “Малчин Ерөө” ХХК, ЕБС, Хүн эмнэлэг зэрэг аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг хамруулсан.

Эрүүл мэндийн төв нь 05-р сарын байдлаар амбулаториор 256 хүнд үзлэг хийсэн. Стационариор 18 хүн хэвтүүлэн 186 ор хоног ашигласан Сумын эмнэлэгт төрсөн эх -0 Эрүүл мэндийн төв нь эхийн эндэгдэл гаргалгүй ажиллаж нийт халдварт өвчний гаралтыг жил дараалан бууруулж, 0-15 насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтыг 100%-д хүргэж, тарилгат халдварт өвчин гаргалгүй ажиллаж байна. Жирэмсний хяналтанд 41 эх хяналтанд байгаа бөгөөд 5 сард шинээр 3 эхийг хяналтанд авсан. 05-р сарын 22-ны өдөр Сүрьеэгүй-Сэлэнгэ хөтөлбөрийн хүрээнд “Уушигний эмгэгийг илрүүлэх үзлэг оношлогоор ХӨСҮТ, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийн баг джитал рентген аппаратаар сүрьеэ өвчнөөр өвдөж байсан түүний хавьтал, гэр бүлийн гишүүд, эрсдэлт бүлгийн 197 хүнийг оношлосон бөгөөд сэжигтэй гарсан 14 хүнд цэрний шинжилгээ хийсэн.

ЕБС-ийн 90 жилийн ойг болохтой холбогдуулан ахмад багш нарт хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг сумын соёлын төвд зохион байгуулсан.

Зүүнбүрэн сум:

Тайлант сард сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 1 удаа хуралдан сумын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аудитын дүгнэлтийн тухай, сумын 2017 оны төсвийн тодотголын тухай, 2017 онд иргэдэд олгох хүнсний ногооны газарт шалгалт явуулсан дүнгийн тухай, сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай, Тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийн тухай зэрэг асуудлыг хэлэлцснээс гадна иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид 1 удаа хуралдаж сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны тухай хэлэлцэн сумын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн даргад нарт үүрэг даалгавар өглөө.

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд хувь хүн, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн үүрэг оролцоог сайжруулах нь сэдэвт сумын зөвлөгөөнийг аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа.

“Малчид тариаланчдын хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, төрийн байгууллагын төлөөлөл 13, аж ахуйн нэгжийн төлөөлөл 5, малчдын төлөөлөл 20, ногоочдын төлөөлөл 18 хамрагдлаа. Хэлэлцүүлгээс тариалан эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэн нь эзэмшлийн талбайгаа хашиж хамгаалах, манаач томилох, малаа байнгын хариулга, маллагаатай байлгах, тариалалтын болон ургац хураалтын үеийн хугацааг тухайн жилийн цаг уурын онцлогт тохируулан тогтоох, бэлчээрийн даац болон сүргийн зохистой харьцаанд тохируулан мал аж ахуйг эрхлэх гэсэн шийдвэрийг гаргаж, гарсан шийдвэрийн дагуу сумын Засаг даргын тариалалтын хугацааг тогтоож, малчин, мал бүхий иргэдийг нүүлгэн шилжүүлэх А/79 тоот захирамж гарган Боонгийн тохойн 8 малчин өрхөд сурталчиллаа.

Сэлэнгэ аймгаас Япон Улсын Шизоүки мужтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тус мужийн газар тариалангийн мэргэжилтнүүд тус

суманд ажиллаж, “Гурвалжин будааг хэрхэн яаж тариалах, арчлах, борлуулах” талаар сургалтыг зохион байгуулж газар тариалангийн үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуйн нэгжийн төлөөлөл, аймаг, сумын удирдлагууд оролцож “Арвин хур” ХХК-ий 40 га талбайд тариалах үрийг өгч хамтран ажиллахаар боллоо. “Алтан тариа” ХХК-иас энэ сарын 18, 19-нд Органик хөдөө аж ахуйн онол практикийн чиглэлээр талбайн болон танхимын сургалтыг зохион байгуулж, сургалтаар органик хөдөө аж ахуйн талаар, ашигт бичил биетийг ашиглах, хөрс арчлах, тариалангийн удирдлагын арга барил, гүзээлзгэнэ, улаан лооль, төмс, хүн орхоодой тарих талаар зааж сургаж Зүүнбүрэн, Сүхбаатар, Цагааннуур сумын газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг 50 гаруй иргэд хамрагдлаа.

Сумын Засаг даргын захирамж гарч төр, төсвийн байгууллагуудын үйлчилгээний чанар, ил тод, нээлттэй шуурхай байдлыг сайжруулж, иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилгоор төрийн албан хаагчдыг бүтээлчээр ажиллуулж, цаг бүртгэлийн тоног төхөөрөмжийг байгууллага бүр ашиглаж, цалин хөлсийг нь олгохдоо цаг ашиглалт, үр дүнг тооцон ажиллахыг төсвийн байгууллагын дарга нарт, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг чанад сахиулж, байгууллагын хэмжээнд ёс зүйн хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, сургалт сурталчилгааны ажлыг тогтмолжуулж ажиллахыг ёс зүйн хорооны дарга нарт тус тус үүрэг болголоо.

Иргэний гэр бүлийн тухай хуулийн хүрээнд шинэ төрсөн 7, эцэг тогтоолт 5, овог нэр өөрчлөлт 1, гэрлэлт 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 9, иргэний үнэмлэх гээгдүүлээд дахин авах 4, иргэний үнэмлэх олголтын 24, шилжин явсан 7, шилжин ирсэн 4 нийт 63 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн ажлын хүрээнд 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 18 цагт шилжилт хөдөлгөөнийг зогсоож, шилжилт хөдөлгөөний дэвтрийг хааж, бүргэлийн маягтуудын хамт аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хүлээлгэн өглөө.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аяны хүрээнд аж ахуйн нэгж байгууллага бүр ажилчиддаа ажилд гарахад нь аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөө өгч, гарын үсэг зуруулан, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, ажлын тусгай хамгаалах хувцас хэрэгслээр ханган, эрх зүйн сургалтыг зохион байгуулж хэвшлээ. Мөн аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт, эмэгтэй хүний хөдөлмөр, цалин хөлс, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр тэтгэмж, ажил амралтын цагийн талаар сурталчилан гарын авлага тараах материалаар 100 иргэнийг хангалаа.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 14, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт 31, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөрт 6, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2 иргэн тус тус бүртгүүлснээс ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 2 иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төсөл хөтөлбөрт 1 иргэн хамрагдахаар судлагдаад байна.

Олон улсын Гэр бүлийн өдрийг угтан зорилтот бүлгийн иргэдийн дунд буухиа тэмцээн зохион байгуулж “Дэлбээ” баг 1 дүгээр байр, “Яргуй” баг 2 дугаар байранд шалгарч өргөмжлөл, медалиар тус тус шагнаж, хүүхдийн сурч хөгжих төлөвших сургалтын таатай орчинг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж буй 3 эцэг, эхийг “Хүүхдэд ээлтэй гэр бүл”-ээр шалгаруулан өргөмжлөл хадгалууллаа.

Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн багш нарт “Сайн туршлага, судалгааны арга зүй” сэдэвт сургалтанд 10 багш, ЕББДС-ийн “Эрүүл мэнд” бүлгийн сурагчид “Шүд, гар угаах дадал” сургалтыг сурагч, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулж 214 сурагч, 34 эцэг эх хамрагдлаа. Мөн Ерөнхий боловсролын сургуулийн орчинд ухаалаг утасны хэрэглээг багасгах зорилгоор “Гар утасны хор уршиг, цахим гадуурхал цаашаа” сургалтыг зохион байгуулж 121 сурагч, Амьдралын зөн хараа” ТББ-ын лектор Ц.Ганчулуун “Гэр бүлийн харилцаа, хүүхдийн хүмүүжил” сэдвээр ахлах ангийн сурагчид, иргэдэд мэдээлэл хийлээ.

Сумын эрүүл мэндийн төвийн амбулаториор 328 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 215, урьдчилан сэргийлэх үзлэгээр 28, диспансерийн хяналтаар 34, гэрийн идэвхтэй эргэлтээр 36, дуудлагаар 15 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүлээ. Ээлжит товлотт вакцинд 1 хүртэлх насны хүүхдүүдийг 100 хувь хамрууллаа. Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн дагуу 0-2 насны хүүхдэд олон найрлагат бичил тэжээлийн холимог олгож, сар бүр жинлэн эхчүүдэд хооллолт асаргааны талаар зөвлөгөөг өгсөн.

Сумын хаврын тариалалтын штабыг томилж, тариалалтын мэдээг аж ахуйн нэгж, иргэн бүрээр авч холбогдох газарт өдөр бүр өгч байна. Одоогийн байдлаар сумын хэмжээнд улаан буудай 5629 га, тэжээлийн ургамал 123 га, рапс 972 га, төмс 35 га, хүнсний ногоо 111,72 га ба тариалалт 75%-тай явагдаж байна.

Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, ажлыг зохион байгуулах зорилгоор гахайн цусан халдварт, дотрын халдварт хордлого, шөвөг яр, гахайн мялзан, гахайн цусан халдварт зэрэг вакцинд хамруулах мал эмнэлгийн ажил үйлчилгээг 2017 оны 05 дугаар сарын 15 –с эхлүүлж 1185 толгой хурга, ишгийг шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд, 50 гаруй нохойг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу төсвөөс нийлүүлэгдсэн 10 нэр төрлийн вакциныг 34780 толгой мал амьтан хамруулахаас, 10300 толгой мал, 1300 толгой амьтанд шаардагдах 6 нэр төрлийн био тарилгыг татан авч, технолгийн дагуу хадгалан зарцуулж байна.

“Мал эмнэлгийн ариун цэвэр, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян” –ны хүрээнд мэргэжлийн байгуулагуудтай хамтран 45 хашаа байр, 178 тн бууц, 41 худаг нийт 26,8 м² талбайд мал эмнэлгийн ариутгал халдваргүйжүүлэлтэнд хамрууллаа.

Бүх нийтээр мод тарих өдрөөр сумын хэмжээнд нарс 62, үрслэгээгээр нарс 1000, улиас 1000, голт бор 20, шар хуйс 100, агч 20, үрхийн нүд 180, нохойн хошуу 70, тэхийн шээг, долоогоно 30 ширхэгийг тус тус тариаллаа.

Мандал сум:

Сумын мал аж ахуйн салбарын цаг үеийн мэдээлэл, тулгамдсан асуудлыг хэлэлцэх, малчдын санал бодлыг сонсох, сумын бодлого шийдвэрийг танилцуулах зорилгоор малчдын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд 260 орчим малчид оролцож мал аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудал түүнийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга замын талаар хэлэлцэж, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын болон мал эмнэлгийн албаны дарга нар салбарын цаг үеийн мэдээлэл, цаашид баримтлах бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өглөө.

Сумын ЗДТГ, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлтэй хамтран байгууллагуудын ХАБЭА хариуцсан албан хаагчдыг чадваржуулах сургалтыг “Сентеррагоулд Монголиа” ХХК дээр зохион байгуулж, тус компаний үйл ажиллагаатай танилцуулан, туршлага судлууллаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэдээ мэдээлэл хийх, спортын арга хэмжээ зохион байгуулан нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний дуу хоолойг сонсч тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Хамтдаа хөгжье” өдөрлөг зохион байгуулж 180 иргэнийг хамрууллаа.

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээнд 222 иргэний материал хүлээн авч, Өрхийн мэдээллийн санд 45 шинэ төрсөн хүүхдийн мэдээллийг бүртгэж орууллаа. Сонсголын дижитал аппарат нийлүүлэх тендерт “Тунгалаг аялгуу” ХХК шалгарч 36 иргэнд 11,880,000 төгрөгний хөнгөлөлт үзүүллээ. “Бум хараа” ХХК-ийн хаш чулуун эмчилгээнд 25 ахмад, 25 хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг хамрууллаа.

Сэлэнгэ аймгийг “Эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэх” сэдэвт олон улсын бага хуралд сумын мал аж ахуй, газар тариалангийн салбарт ажиллаж буй тариаланч-3, малчин 7, Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга,

Багийн дарга нар, газрын даамал нийт 23 хүний бүрэлдэхүүтэй оролцож санал бодлоо солилцлоо.

Сумын хэмжээнд 5260 га-д үр тариа, 450 га-д төмс, 320 га-д хүнсний ногоо, 20 га-д тэжээлийн ургамал тариалаад байна. Тариалалт 62,0 хувьтай байна.

Мал төллөлтийн мэдээгээр сумын дүнгээр 52510 хээлтэгч мал төллөхөөс 35857 толгой мал төллөж, төл бойжилт 98,6 хувьтай байна.

МУ-ын ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 тоот зарлиг, 2013 оны 178 дугаар зарлиг, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2017 оны А/83 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 2017 оны А/210 тоот захирамж, Мандал сумын Засаг Даргын 2017 оны 167 тоот захирамжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг 2017 оны 05-р сарын 13-14–ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 936 иргэн 117 аж ахуйн нэгж, байгууллага 1896 мод, бут, сөөг тарилаа.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, ойд үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар зогсоох тухай” сумын Засаг даргын 135 тоот захирамжийн дагуу Дарьт-Орхироо, Шивэр, Тарни, Хэрх, Түнхэлийн эх, Балж, Итэм-Нэмэх гэсэн 7 чиглэлд ой хээрийн түймрийн төв пост, хуурайшилтын үеийн хариуцлагатай жижүүр хуваарийн дагуу ажиллаж байна.

2017 оны 04 сарын 26-нд Шаржалга гэх газар давтан түймэр гарч Онцгой байдлын хэлтэсээс 24 албан хаагч болон сумын иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд дайчлагдан 6 өдөр ажиллаж, түймрийг унтраасан. Түймрийн улмаас 78 га талбайг шатсан байна. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх санамж, гарын авлага тараах материалаар хангахаас гадна 4 аж ахуйн нэгж, байгууллагаас тус бүр 5 ширхэг хүрз, 20 ширхэг тросон шүүр зэрэг нийт 100 ширхэг түймэр унтраах багаж хэрэгсэл бэлтгэж төвлөрүүллээ.

Орхон сум:

Төрийн албан хаагчдын дунд тохилог орчин бий болгох, ажлын байрыг эмх цэгцтэй иргэд үйлчлүүлэгчдэд таатай үйлчлэх орчинг бүрдүүлэх зорилгоор “Миний ажлын байр-Миний гэр” аяныг зохион байгуулж байна. Мөн “Тайлан-мэдээлэл-Санал шийдэл” иргэдтэй уулзах өдрийн хүрээнд сумын Засаг дарга цаг үеийн мэдээ мэдээлэл хийж, Нийгмийн даатгал амьдралын баталгаа болох нь, газар өмчлөл, эзэмшил, ашиглалт, эрх шилжүүлэхэд иргэдийн анхаарах асуудал, Малчид тариаланчдын газар эзэмших ашиглалттай холбогдсон асуудал, Шилдэг хэсэг шалгаруулах уралдааны явцыг танилцуулж, 64 төрийн албан хаагч 31 иргэн хамрагдсан байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны сахилга хариуцлагыг сайжруулах тухай 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын “Ажлын хариуцлага, цаг ашиглалтыг сайжруулж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/181 тоот захирамж гарч төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч, төрийн албан хаагчидтай холбоотой иргэд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг 2 удаа зохион байгуулж үр дүнг тооцон анализ хийж ажилласан. Тус үнэлгээгээр сумын ЗДТГ-ын дарга 75.7%, ЕБС-ийн захирал 83.4%, цэцэрлэгийн эрхлэгч 78.3%, Соёлын төвийн эрхлэгч 78.3%, ЭМТ-ийн эрхлэгч 72.4%, төрийн захиргааны албан хаагчид дунджаар 78.2%-ийн үнэлгээтэйгээр тус тус дүгнэгдлээ.

Цэргийн жинхэнэ албаны татлага болж хамрагдвал зохих 73 цэргийн насны иргэдээс 46 хамрагдаж 71 хувьтай зохион байгуулагдлаа. Мөн шалтгаангүйгээр тасалсан 3 иргэн, мөнгөн төлбөрөөр цэргийн албыг хаах хүсэлт гаргасан 6 иргэнийг материалыг аймгийн Цэргийн штабт хүргүүллээ.

Тус сумын ЗДТГазар Соёлын төвтэй хамтран Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүл бүхэн жаргалтай байг” уриан дор “ШИЛДЭГ ГЭР БҮЛ-2017” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд залуу хойч үеийнхэнд үлгэр жишээ болсон 6-аас дээш хүүхэд төрүүлэн өсгөсөн, үр хүүхдүүд нь бүгдээрээ улсад болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа “Олон хүүхэдтэй гэр бүл”, гэр бүлээрээ удам дамжсан газар тариалан эрхэлж байгаа, аймаг орон нутгийн газар

тариалангийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байгаа “Тариаланч гэр бүл”, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуйг хослон ажиллаж байгаа, малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлж, малч ажиллагаагаараа олонд танигдаж яваа “Залуу малчин гэр бүл”, гэр бүлээрээ спортын ямар нэг төрлөөр хичээллэдэг, улс аймаг, бүсийн тэмцээн уралдаанд амжилттай оролцож байгаа “Спортлог гэр бүл”-ийг шалгаруулан өргөмжилж хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа.

МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд 0,5 га талбайг хашаажуулан 365 ширхэг нарс модыг тарьж суулгасан. Тус ажилд төр төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, нийт 109 хүн оролцсон.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 4 төрлийн вакцинжуулалтанд төлөвлөгөөний дагуу 9800 толгой мал хамрагдахаас 8600 мал хамрагдаж 88 хувийн биелэлтэй байна. Мөн сумын Засаг даргын 2017 оны “Цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тухай” А/67 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдон сумын бүх хонин сүрэгт 1 удаа, хурганд 14 хоногийн зайтай 2 удаа хийхээр вакцин хийж, давхардсан тоогоор 83,4 мянган толгой мал хамруулахаас 40,0 мянган толгой мал хамруулаад байна.

Аймгийн ХХААГ-аас “ОХУ-ын Эрхүү мужид гахайн мялзан өвчин гарсантай холбогдуулан ирүүлсэн сэрэмжлүүлгийн дагуу сумын гахайтай өрхийн судалгаа гаргаж, гахайг байранд маллах, гаднаас гахай авахгүй байх хашаа хороог цэвэрлэж байх зэрэг зөвлөмж бэлтгэн тараасан.

Сумын хэмжээнд мал төллөлт төл бойжилт хэвийн явагдаж бод малын 58,8 хувь, Бог малын 80 хувь төллөөд байна. Оны эхний нийт хээлтэгч эх малын 77,1 хувь төллөж гарсан төлийн 99,5 хувь бойжиж, төлийн хорогдол 0,4 хувьтай байна

2017 оны Татвар төлөгчдийн өдрүүдийг удирдамжийн дагуу зохион байгууллаа. “Би ирээдүйн татвар төлөгч” ЕБС-ийн ахлах, дунд, бага ангийн нийт 63 сурагчдад нээлттэй хичээлийг зохион байгууллаа. Тус хичээлээр 5а ангийн 18 сурагчид Татвар төлөгч аав, ээж, ах, эгч нартаа зориулан талархал дэвшүүлсэн ил захидал бичиж 12 аж ахуйн нэгж, 6 иргэнд хүргэсэн. Ахмадын холбоотой хамтран 21 ахмадад Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем /НӨАТУС/-ийн талаар сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд хамрагдсан ахмадууд сугалааны баримтаа бүртгүүлэх бүртгэлээ нээлгэж хэрэглэгчийн нэр, нууц кодоо авсан.

Баянгол сум:

“Хүний эрхийн төлөө хамтдаа” аяныг 5-р сарын 08-20-ны өдрүүдэд зохион байгуулж, аж, ахуйн нэгж, байгууллагаар Хүний эрхийн төлөө хамтдаа аяны туг аялах хуваарь гарган хэрэгжүүлэн ажиллалаа. Аяныг сумын хэмжээнд сурталчлах зорилгоор хулдаасан хэвлэл, Хүний эрхийн салбар хорооны мэдээлэл самбарыг хийлгэн иргэдийг Хүний эрхийн мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үүднээс Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааны талаар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиудыг сурталчлан давхардсан тоогоор 498 иргэнийг сургалтад хамруулж мэдлэг боловсролыг дээшлүүлсэн байна. Мөн Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн орон нутаг дахь хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтийн санал бодлыг судлан дүгнэлт гаргах судалгаанд Баянгол сумын нийт 318 иргэнээс санал авч нэгтгэн хүргүүлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөл нь УБТЗ-ын 1 дүгээр ангийн 10 дугаар хэсэг, Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн анги, Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги, Баруунхараа өртөө болон шатахуун түгээх станцын ажилчид бие бүрэлдэхүүн нийт 134 ажилтан, албан хаагчдад мэдээлэл хийж холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг сурталчлан, иргэдийн асуулт санал хүсэлтийг хүлээн авч харилцан ярилцаж ажил хэрэгч үр дүнтэй уулзалтыг зохион байгууллаа.

2017.05.11-ний өдөр сумын нутаг дэвсгэрт худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэд, аж ахуй нэгж байгууллага, компанийн захирал, хүнсний мухлаг, дэлгүүрийн худалдагч нарт Монгол Улсын Үндсэн хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хүнсний аюулгүй байдлын тухай хуулиар сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 46 иргэн хамрагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлиг, БОНХАЖС-ын 2015 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/146 тоот тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны А/210 дугаар захирамжийн хүрээнд “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг зохион байгуулж ажиллалаа.

Бүх нийтийн мод тарих үндэсний өдөр 2017.05.15-ны өдөр зохион байгуулагдан сумын хэмжээнд 15 аж ахуйн нэгж байгууллага 6 иргэн идэвхтэй оролцож 5 нэр төрлийн 405 ш мод тарилаа.

Жил бүр уламжлан болгон тэмдэглэн өнгөрүүлдэг “Татвар төлөгчдийн өдөр”-өөр Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсээс ирсэн удирдамжийн дагуу татвар төлөгчдийн өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2017.05.08-2017.05.13-ны өдрийн хооронд сумандаа зохион байгуулан сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээлэл, сурталчлгааны материалаар татвар төлөгчдийг ханган ажиллалаа.

Сумын Засаг даргаар “Татвар төлөгчийн өдрүүд”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан төлөвлөгөөний дагуу ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Татвар төлөгчдийн өдрүүдээр татварын хууль тогтоомжийг сурталчлах, заавар зөвлөгөө өгөх, сурталчилгаа хийх, аргачлал гарын авлага материалаар татвар төлөгчдийг ханган 85 татвар төлөгчдөд үйлчлэн ажилласан. Мөн хуулийн мэдээ мэдээллийг мэдээллийн самбарт байршуулан, цахим хэрэгсэл, урсдаг самбараар мэдээлэл түгээж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн ажлын байранд хуулийн сурталчилгаа хийж гарын авлага, брошур тараасан.

НӨАТУС-ийн байнгын хэрэгжилтийг хангах үүднээс байгууллагуудаар сургалт хийсэн ба ААН-дэд стикер наалт, сурталчилгааны материал тарааж ажилласан. Мөн Сэлэнгэ аймагт болсон татвар төлөгчийн зөвлөгөөнд 10 аж ахуй нэгж оролцсон.

18 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа татвар төлөгчийн өдрүүдээр Монгол улсын Татварын хуулийг шударгаар сахиж, Үндсэн хуулиар хүлээсэн албан татвар төлөх үүргээ нэр төртэй биелүүлж, улс орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр оруулсан шилдэг татвар төлөгчөөр ТЕГ-ын хэмжээд Хос түрүү ХХК, Майндтэч ХХК, иргэн Ц.Зундуй нар баярын өдөр талархалаар шагнууллаа.

Эхний 5 сарын байдлаар суманд нийт 50.1 сая төгрөгийн орлого оруулахаас 29.0 сая төгрөг оруулж, орлогын төлөвлөгөөний биелэлт 57.8 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн сарын орлогын төлөвлөгөөний биелэлтээс 12.3 хувиар өссөн дүнтэй байна. Цаашид орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг 100 хувь болгохоор ажиллаж байна.

УТБДС-ийн хамтын ажиллагааны хүрээнд Тайваны Жинхуа хотын Чиен Күо Технологийн их сургуулийн төлөөллийг энэ сарын 13-нд хүлээн авч уулзалт хийсэн. Уулзалтын хүрээнд төгсөх 12-р ангийн сурагчдад Чиен Күо Технологийн их сургуулийнхаа танилцуулгыг хийж гадаадад суралцах талаар арга зүйн зөвлөгөө өглөө.

Нэрт яруу найрагч Гомбын Сэр-Одын мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд сургалтын менежер Г.Мөнгөнчимэгээр ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан Г.Сэр-Одын амьдрал, уран бүтээлийг сурталчлах, нийтэд мэдээлэх гээд олон ажил арга хэмжээг зохион байгуулж байна. Тухайлбал сурагчдын дунд Г.Сэр-Одын амьдрал уран бүтээлийг сурталчлан таниулж, Шүлгэн хэлхээ наадмаа амжилттай зохион байгууллаа.

“Соёл мэдээллийн цаг”-ийн хаалтын арга хэмжээг “Бид мартахгүй” Монгол киноны дууны хүндэтгэлийн тоглолтыг тавьж 11 байгууллагын 23 албан хаагч оролцсон. Хаалтын арга хэмжээг 150 хүн үзэж сонирхсон. Мэдээллийн цагийн арга хэмжээний шилдэгүүдийг тодруулан сумын Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Тэргүүн байрыг БДС, 2 дугаар байрыг “Солонго”-

цэцэрлэг, Баруунхараа УЦУС, 3 дугаар байрын Улсын нөөц, ХААН, Төрийн банкнууд эзэлсэн байна. Мэдээллийн цагийн арга хэмжээ нь хөтөлбөрийн дагуу урлагийн 5, спортын 4, түүх соёлын 3 нийт 12 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 5000 гаруй иргэн хамрагдсан байна.

Мөн Баян багийн иргэн Л.Олдохын “Мөнхөд эгшиглэх аялгуу” гэр бүлийн тоглолт, Хараа багийн иргэн Д.Эрдэнэхүү агсны нэрэмжит сагсан бөмбөгийн тэмцээний нээлтийн арга хэмжээний урлагийн тоглолтыг зохион байгуулж давхардсан тоогоор 450 гаруй хүн хамрагдсан байна.

Сумын амбулаториор нийт 498 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 306 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн. Стационарт 56 хүнийг хэвтүүлэн 650.0 мян/төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулан эмчилсэн. Эх хүүхдийн эрүүл мэнд хоол тэжээл хөтөлбөрийн хүрээнд 0-5 насны 216 хүүхдийг жинлэн, товллын дагуух дархлаажуулалтад 100 хувь хамруулсан.

Сүрьеэгүй Сэлэнгэ хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн болон хавьтлын судалгааны дагуу Улаанбаатар хотын ХӨСҮТ-тйн эмч нарыг урьж ирүүлэн джитал рентген аппаратаар цээжний флюор шинжилгээнд 314 иргэнийг хамруулсан. Эрт илрүүлэгийн шинжилгээгээр 1 шинэ тохиолдлыг илрүүлэн аймгийн сүрьеэгийн диспансерийн хяналтад шилжүүлэн, эрчимт эмчилгээг сүрьеэгийн тасагт хэвтүүлэн эмчлүүлж байна. “Сүрьеэгүй ирээдүйн төлөө нэгдэцгээе” сэдэвт сургалтыг багийн 186 иргэнд хийсэн. Жирэмсэн болон хөхүүл 65, 0-59 сар хүртэлх насны 133 хүүхдэд хэмжилт хийж ягаан дэвтэрт тэмдэглэл хөтөлсөн.

Сумын хэмжээнд хаврын тариалалтын ажлыг зохион байгуулан, тариалалтын мэдээг шуурхай авч тариаланчдыг холбогдох мэдээлэл, зөвлөмжөөр хангах үүрэг бүхий тариалалтын штабыг сумын засаг даргын 05 сарын 10-ны өдрийн А/81 тоот захирамжаар томилон ажиллаж байна. 2017 оны 05 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 6079 га-д үр тариа, тэжээл, тосны ургамал тариалсан. Үүнд: 5917 га улаанбуудай, 177 га овъёос, 45 га ногоон тэжээл, 30 га рапс тариалсан байна. Үр тарианы тариалалт 76,8 хувьтай байна. Төмс хүнсний ногооны салбарын хувьд 46,4 га-д төмс, 34 га-д хүнсний ногоо тариалсан 40 хувьтай байна.

2017 онд сумын хэмжээнд 70561 толгой мал төллөхөөс 05 сарын 19-ны өдрийн байдлаар 57108 толгой мал төллөж, төл бойжилт 99,3 хувьтай байна. Үүнд: Төллөсөн гүү 1320, үнээ 4044, эм хонь 34024, эм ямаа 17720 толгой байна. Том малын хорогдол 764 толгой. Үүнд: адуу-44, үхэр-209, хонь-290, ямаа-221 байна. Халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Шөвөг яр, ДХХ, Дуут галзуугийн вакцин хуваарлагдан ирэн 4 мал эмнэлэг вакцинжуулалтын ажлыг эхүүлж одоогийн байдлаар тарилгын ажил 80 гаруй хувьтай явж байна. Хонины Цэцэг өвчний вакцин 94000 тун ирснээс 20000 толгойд хийгээд байна.

Орхонтуул сум:

Сумын Засаг даргын Зөвлөл 05-р сарын 16-ны өдөр хуралдаж, зуслан, намаржааны газрын хуваарь тогтоох тухай, иргэдээс ирүүлсэн өргөдлүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай, соёлын төвийн 2017 оны 1 дүгээр улирлын тайлан сонсож, 2016 оны 10-р сард гарсан хонины гоц халдварт цэцэг өвчнийг дахин гаргахгүй байх, бэлчээр ус хамгаалах зорилгоор малын шилжилт хөдөлгөөнийг хориглож, өвчний голомттой өрхүүдэд тодорхой газар зааж нутаглуулахаар шийдвэр гаргалаа. Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, сумын Соёлын төвийн 1-р улирлын ажлын тайланг сонсоод малчдад урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх явуулын арга хэмжээг тогтмолжуулах талаар тус байгууллагын эрхлэгчид үүрэг даалгавар өгсөн байна.

Тайлант сард иргэдээс нийт-8 өргөдөл ирүүлсэн байна. Сумын Засаг даргын Зөвлөлийн 05-р сарын 16-ны өдрийн хурлаар 6 өргөдлийг хэлэлцэж хариуг албан тоотоор хүргүүллээ. Иргэдээс худаг гаргах, худаг уст цэгтэй холбоотой хүсэлт-3,

мөнгөн тусламж хүссэн-1, ажил хүссэн-1, загас үржүүлгийн чиглэлээр газар эзэмших хүсэлт-1 ирүүлсэн байна. Хугацаа болоогүй 2 өргөдлийг бүртгэж шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. Иргэдийн санал хүсэлтийг 96201416 дугаарын утсаар тогтмол авч байна.

Тус суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Шидэт хөрс”ХХК-ны урилгаар хөдөлмөрийн гэрээгээр Хятад улсын 7 иргэн ирсэнийг Рашаант тосгоны Улсын бүртгэгч түр оршин суугчаар бүртгүүлэх шаардлага тависнаар бүртгэж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст мэдээ хүргүүллээ.

Иргэдэд мэдээлэл хүргэх, шинээр батлагдсан хууль тогтоомжуудыг сурталчилах зорилгоор “Явуулын иргэний танхим” арга хэмжээг зохион байгуулж байна. Тайланд сард Баянцогт 2-р багийн нутаг Замын булаг, Жаргалант булаг, Наран, Хөхий, Бяцхан ус зэрэг газруудад хаваржиж байгаа малчдыг хамруулан зохион байгууллаа. Малчдад мэдээлэл өгч, хууль тогтоомж танилцуулахаас гадна караоке тэмцээн зохион байгуулж шагнаж урамшууллаа.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан суманд үйл ажиллагаа явуулж байгаа ашигт малтмалын болон газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгжүүдтэй Нийгмийн хариуцлагын гэрээ байгууллаа. Эхний ээлжинд газар тариалан эрхлэгч 6 аж ахуй нэгжтэй хариуцлагын гэрээ байгуулаад байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ.

Тариаланчдын улсын зөвлөгөөнд 13 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлийг, аймгийн зөвлөгөөнд 8 иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллийг тус тус оролцуулснаас гадна сумын тариаланчдын зөвлөгөөн 5-р сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр сумын “Тариаланчдын зөвлөл”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Түүнчлэн Сэлэнгэ аймгийг эрчимжсэн мал аж ахуй газар тариалангийн стратегийн бүс нутаг болгох Олон улсын онол үйлдвэрлэлийн бага хуралд оролцож хурлаас гарсан зөвлөж шийдвэрийг малчид, тариаланчдад сурталчилах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2017 онд бүгд 216,060 толгой мал тоологдсоноос нийт малын 44.5%-ийг буюу 96290 хээлтэгч мал эзэлж байна. Он гарсаар 4862 толгой мал зүй бусаар хорогдсоноос адуу 303, үхэр 752, хонь 2029, ямаа 1778 толгой хорогдсон байна. Зүй бусаар хорогдсон малын 214 толгой буюу 4,4% өвчнөөр хорогдож, 4648 мал бусад шалтгаанаар хорогдоод байна. Оны эхний төллөх 96290 хээлтэгчийн 77,7% буюу 74867 толгой хээлтэгч мал төллөж гарсан төлийн 98,7% буюу 73998 толгой төл бойжиж байна. Үүнээс ингэ 54, гүү 2183, үнээ 4267, эм хонь 41475, ямаа 26888 төллөж одоогоор ботго 51, унага 2125, тугал 4186, хурга 41004, ишиг 26632 бойжиж байна. Бүгд 931 толгой төл хорогдсоноос ботго 3, унага 58, тугал 81, хурга 500, ишиг 289 толгой хорогдоод байна.

Тайлангийн сард мал аж ахуйн үйлдвэрлэлийн хүрээнд ямааны ноолуур самнах ажил үндсэндээ дуусаж нийт 24,1 тн ноолуур үйлдвэрлэн зах зээлд борлуулаад байна.

2017 онд 19 аж ахуйн нэгж, 12 иргэн газар тариалангийн чиглэлээр үйлдвэрлэл явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж одоогийн байдлаар 10740 га-д тариалалт хийснээс улаан буудай 9359 га, рапс 1375 га-д, төмс 4,5 га-д, хүнсний ногоо 1,5 га-д тариалалт хийгээд байна. Хаврын тариалалт эхэлж тариалсан талбайд мал орохоос урьдчилан сэргийлэх үүднээс тариалсан талбайд ойролцоо байгаа малчдыг нүүлгэх ажлыг хэрэгжүүлэн албан мэдэгдэл, шаардлага хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын захирамжийн дагуу томилогдсон ажлын хэсэг гарч малчдад сарын ажлын зорилго ач холбогдлыг танилцуулж суурь малчдаар явж 2016-2017 оны өвөл хаврын улиралд хорогдсон малын хүүр сэг зэмийг устгах, хот орчмын ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах хашаа, хороо, өтөг бууц ариутгах ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа. Сарын ажлын хугацаанд үхсэн малын сэгийг устгах ажилд нэг трактор, авто машин 3 ажиллаж хүүр сэг зэмийг устгаж халдваргүйжүүлэлт

хийж булж устгалаа. Үүнд нийт 24 адуу, 145 үхэр, 1200 хонь, 1164 ямааны сэг зэмийг булж устгах ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа. Энэ хугацаанд малын өвөлжөө хашаа 45 хашааны 450 м2 талбайг ариутгасан.

2017 онд мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэн одоогийн байдлаар шөвөг ярын вакциныг 8500 богийн төлд, ДХХ-ыг 3400 богт, цусан халдвартын вакциныг 2680 толгой бодод, гахайн мялзангийн вакцинныг 200 толгой гахайд хийгээд байна.

Малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 мал эмнэлэг 5-р сарын 22-ны байдлаар 35400 толгой хонинд вакцинжуулалт хийгээд байна.

Тайлангийн сард 46 малчин ба мал бүхий өрхөөр очиж мал өвөлжилт хаваржилт төл бойжилтын ажил төрөлтэй нь танилцаж ажлын талаар тодорхой үүрэг даалгавар өгч ажиллалаа. Энэ хугацаанд нийт 8 удаагийн малын дуудлагаар үйлчлэн заавар зөвлөгөө өглөө. Сумын төвийн айл өрхүүдийн 56 үхэрт ээмэгжүүлэлт хийж гүйцэтгэсэн байна.

Баруунбүрэн сум:

Сумын тариаланчдын зөвлөгөөнийг 2017 оны 4-р сарын 28-ны өдөр “Бүрэн Сэлэнгэ” ХХК, газар тариалан эрхэлдэг иргэдтэй хамтран амжилттай зохион байгуулж, зөвлөгөөнд 60 гаруй тариаланч оролцсон. Сумын хэмжээнд одоогийн байдлаар 7615 га талбайд улаан буудай, 350 га талбайд рапс, 65 га талбайд төмс, 53,5 га талбайд хүнсний ногоо тариалаад байна. Тариалалтанд нөөцөлсөн үртэй аж ахуй нэгжүүдийн үрийг аймгийн МХГ-т хүргүүлж шинжилгээнд хамруулсан.

Сумын хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шөвөг яр өвчний вакциныг 7300 толгой ишгэнд, доторын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 3200 толгой хонинд, дуут хавдар өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 4400 толгой үхэрт, гахайн мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 100 толгой гахайнд тус тус хийсэн.

Сумын хэмжээнд нийт 1340 толгой мал хорогдсноос адуу 50, үхэр 230, хонь 520, ямаа 540 толгой хорогдж, мал төллөлт, төл бойжилтын хувьд 80089 толгой хээлтэгч төллөхөөс одоогийн байдлаар 50745 толгой мал төллөснөөс ингэ 3, гүү 200, үнээ 2300, эм хонь 30173, эм ямаа 18069 төллөсөн байна.

Тайлант сард тус сумын Бургалтайн 2 дугаар багийн нутаг Алтан тэвш, Ивэнгийн 1 дүгээр багийн нутаг Хавчуу зэрэг газруудад ойн болон тал хээрийн түймэр гарч, түймрийг унтраах ажлын шуурхай зохион байгуулж, түймрийн хохиролыг тогтоон, зөрчил гаргасан иргэнд холбогдох хуулийн дагуу захиргааны арга хэмжээ аваад байна. Түймрийн багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх зорилгоор байгууллага, аж ахуй нэгжийн ажилчин нэг бүрээр түймрийн багаж /резинэн цохиур, троссон шүүр гэх мэт/ хийлгэж нөөцөнд аваад байна.

Ойн санд тархсан хөнөөлт шавжтай хийх тэмцлийн ажлын хүрээнд 4000 га талбайд 2100 кг өндөг түүж холбогдох журмын дагуу булж устгах арга хэмжээ авсан. Мөн тус суманд үйл ажиллагаа явуулдаг “Соёолж” ХХК-ны мод үржүүлгийн газар өөрийн хөрөнгөөр арчилгааны гэрэлжүүлэх, огтлолт хийх, талбай тусгаарлалтын ажлыг 101 га талбайд хийсэн. Ойн анги нөхөрлөлүүдэд “Ой бүхий аймгуудын биологийн олон янз байдлыг хамгаалал, тогтвортой менежмент нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх” төслийн санхүүжилтээр ОСХТ-өөс “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх арга технологи” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд Баруунбүрэн сумын “Байгалийн хишиг”, “Бүрэн тоонч”, “Ногоон сан”, “Түвшинбүрэн”, “Бумбат хангай”, “Далт” нөхөрлөлүүд болон Ерөө сумаас хоёр нөхөрлөл оролцон нийт 14 хүнийг хамрагдсан.

Бүх нийтээр мод тарих өдрөөр 9 байгууллага, аж ахуй нэгжийн 123 иргэн хамрагдаж 1000 ширхэг /Агч, Шар хуайс, Хайлаас/ модыг тарьж, өмнөх жилүүдэд таригдсан мод, бутыг услах, арчлах, хашааг шинээр барих, сэргээн засварлах зэрэг ажлуудыг хийж, 1006800 төгрөгийг зарцуулаад байна.

2017 оны сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлэхээр тусгагдсан газруудаас Гэсэр

хороололд 112 нэгж талбарыг 112 иргэнд үнэ төлбөргүйгээр өмчлүүлэн нэгж талбарын хувийн хэргийг бүрдүүлээд байна. Мөн 116 иргэний 120 нэгж талбарын кадастрын зургийг Сэлэнгэ аймгийн “Сод сүрвэй” ХХК-аар гүйцэтгүүлэн улсын бүртгэлд бүртгэсэн.

Сумын эрүүл мэндийн төвөөс тайлант сард амбулаторийн үзлэг-211, урьдчилан сэргийлэх үзлэг-121 хийж, осол гэмтлийн өвчлөл-18, эмнэлэгт хэвтсэн- 20, шинжилгээнд хамрагдсан –154, жирэмсний хяналтанд байгаа-28, шинээр жирэмсний хяналтанд орсон-6 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Улсын хэмжээнд хийгдэж буй улаанбурхан, улаанууд өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд нийт 86 хүүхдийг хамруулсан байна.

ЕБС-ийн сурагчдын ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор “Газар Агро” ХХК-ий хандиваар дотуур байрны гал тогооны сандал ширээг 2.500.000 төгрөгөөр, Үдийн цайны гал тогооны хоол цай зөөх зориулалтын тэргэнцэрийг 200,000 төгрөгөөр авлаа. Мөн хүүхдийн тусламжийн утас-108 нь хүүхдийн санаа бодлыг сонсох, хүүхдэд шаардлагатай сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, мэдээлэлээр хангах, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд холбон зуучлах бие махбод зэрэг эрсдэлтэй тохиолдолд хэрхэн үйлчилгээ авах талаарх сургалтыг сургуулийн 6-10-р ангийн 137 сурагчийг хамруулан дээрх сургалтыг зохион явуулав.

Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Уг аяны хүрээнд сумын тариаланчдын зөвлөгөөнөөр хөдөө аж ахуй тасагтай хамтран газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллага, иргэдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилт, цаашдын чиг хандлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн ослын тухай ойлголтын талаар болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны тэмдэг тэмдэглэгээ, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх, ажил, амралтын цаг, цалин хөлстэй холбоотой гарын авлага 190 гаруй ширхэгийг тараан ажилласан. Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилтан тус суманд байхгүй болно. Шинэ Орос хийц ХХК, Бүрэн дулаан ХХК, МТ, Петровис ШТСтанцын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаарх заавар зөвлөгөөтэй танилцан зөвлөгөө өгсөн. Мөн Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Эрсдэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг судалгааны маягтын дагуу гаргаж аймгийн ГБХЗХГазарт хүргүүлсэн.

Угийн бичиг хөтлөх олон нийтийн санаачлагыг өрнүүлэх, Гэр бүлийн цэцэрлэг, Монгол гэр арга хэмжээг тус тус зохион байгуулж, гийн бичиг хөтлөх булан гарган таницуулга бэлтгэн сумын орон нутаг судлах танхимаар дамжуулан сурталчилгааг хийж, 315 өрхөөс судалгааг гаргуулснаас гадна цэцэрлэгийн хүүхдүүдэд орон нутаг судлах музейгээр дамжуулан монгол гэрийн талаар сургалт зохион явууллаа.

Төрийн санд 2017 оны 05 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 46465.6 орохоос гүйцэтгэлээр 33302.4 мянган төгрөг орж биелэлт 71.7%-ийн биелэлттэй байна. Туслах үйл ажиллагааны орлого болон үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөгөөр 16259.8 мянган төгрөг орохоос гүйцэтгэл нь 11293.6 мянган төгрөг төвлөрч биелэлт 69.5%-тай байна.Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 560382.9 мянган төгрөг ирэхээс 560382.9 ирж гүйцэтгэл нь 100% санхүүжигдсэн.

Сумын ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар 2016 оны төсвийн гүйцэтгэл болон 2017 оны төсвийн тодотголыг хэлэлцүүлэн батлуулсан.

Сүхбаатар сум:

Сүхбаатар сум үүсгэн байгуулагдсны 80-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх сумын Засаг даргын А/71 тоот захирамжаар 4 салбар хороог 60 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон, бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар хүсэлт гаргасан нийт 12 аж ахуйн нэгж, байгууллагын 136 иргэний шагналын баримтын бүрдлийг холбогдох журмын дагуу хүлээн авч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох дээд

газарт уламжилсан. Сургууль цэцэрлэгүүд бүтээлч ажил өрнүүлж байгаагийн нэг нь нийт сургуулиуд сумын түүхийн талаар 1 цагийн хичээлийг бүх ангиудад зааж, ойн арга хэмжээг сурталчилсан. Мөн Улсын тэргүүний 4-р сургууль жил бүр зохион байгуулдаг “Эко” аялалын хүрээнд “Гэрэлт цогцолбор”-ын эргэн тойронд 4га газрын хог цэвэрлэгээг хийлээ.

Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Мэргэжилийн хяналтын газар хамтран хяналтын байгууллага үүсч хөгжсний 20 жил, Биеийн тамир, спортын байгууллага үүсч хөгжсний 70 жилийн ойн хүрээнд 65 аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагчдыг оролцуулан биеийн тамир спортоор биеэ чийрэгжүүлэх, цагийг зөв боловсон өнгөрүүлэх, байгууллагуудын хамтран ажиллах хүрээг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцох 20/80 явган аялалыг энэ сарын 28-нд зохион байгууллаа.

Сүхбаатар сумын Засаг даргын захирамжаар цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2017 оны шинэчилсэн тоо бүртгэлийг 01-р сарын 02-16-ны өдрүүдэд уртасгасан цагаар ажиллаж, Цэргийн албаны тухай хуулийг сурталчлах ажлыг багийн иргэдэд зохион байгуулан ажиллалаа. Бүртгэлд 18-50 насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд нийт 782 иргэн хамрагдахаас 750 иргэн хамрагдаж 95.9 хувьтай ажиллаж урьд жилийнхээс өссөн үзүүлэлттэй байна. Сүхбаатар сумын хэмжээнд цэргийн албанд тэнцсэн 23 иргэдийн холбогдох материалуудыг бүрдүүлэн аймгийн цэргийн хэлтэст хүлээлгэн өглөө.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалтыг 8-н багийн 43 иргэнд, “Аз жаргалтай гэр бүлийн 10 гайхамшиг”, “Гэр бүлийн үүрэг”, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”-нд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг танилцуулан иргэдийн дунд харилцан ярилцаж, хэлэлцүүлэг явууллаа. Мөн сургууль, цэцэрлэг бүр эцэг эхийн уулзалт өдөрлөг хийж 1,2,4-р сургуульд төгсөх ангийн хүүхдүүдийн эцэг эхийн зөвлөгөн зохион байгуулж, 420 гаруй эцэг эхчүүд хамрагдлаа. Арга хэмжээний хүрээнд МУУГЗ М. Бямбасүрэнгийн гэр бүл үр хүүхдүүд дүү нарын хамт “Жанжины хотын жаргалтай гэр бүл” тоглолтоо зохион байгуулж, Сүхбаатар сумын “Авьяаслаг гэр бүл” өргөмжлөлөөр шагнагдлаа.

Угийн бичиг хөтлөх ажлыг сургууль, цэцэрлэгт, баг бүрт зохион байгуулах, угийн бичиг хөтлөдөг гэр бүлийг орон нутгийн ТВ-ээр сурталчлах ажлыг Хэвлэл мэдээллийн ажилтан, багийн Засаг дарга нар, нийгмийн ажилтнууд зохион байгуулж, 1-р багийн иргэн Мягмаржавын гэр бүлийн Угийн бичиг хөтлөх аргыг сурталчилан 8 багийн 32 хүнд Угийн бичгийн сургалт хийлээ.

Сүхбаатар сумын хэмжээнд мах махан бүтээгдэхүүн худалдан борлуулж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, Олон Улсын Худалдааны Төв болон “Гурван Мэргэд” хүнсний зах, “Цаст Булган Хангай” ХХК-ний ажилчид болон мах худалдан борлуулж байгаа түрээслэгч нар эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан, мэргэжлийн худалдагчийн үнэмлэхтэй, хүнсний түүхий эд болох махыг мал эмнэлэгийн шинжилгээнд тогтмол хамрагдаж байгаад хяналт тавьж ажилласан. Шалгалтын явцад нийт 3 аж ахуй нэгж, 4-н махны мухлаг, 53 иргэн хяналт шалгалтанд хамрагдлаа. Шалгалтаар аж ахуй нэгж, иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжил арга зүйн зөвлөмж өгч аж ахуйн нэгж, иргэдийг Хот тохижилт үйлчилгээний газартай хог хаягдалын тухай гэрээний дагуу бүгд хог хаягдалаа тохижилт үйлчилгээний газраар ачуулсан байна.

Мөн Сүхбаатар сумын [Web сайт](#)-аар аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэдэд хандан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, “Зар сурталчилгааны тухай” хуулийг хэвлэл мэдээлэлээр сурталчилан 70362053 утсаар иргэдээс санал гомдолыг хүлээн авч цаг хугацаанд нь шуурхай арга хэмжээ авч ажиллаж байна. Хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөж байгаа талаар аймгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэгийн дарга, сумын ХАА-н тасаг, худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн нар талх талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа нийт 12 аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавьж 64 ажилчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бүтээгдэхүүн, нарийн боов үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд дүгнэлт хийхэд хаяг шошго, жин хэмжээтэйгээ таарч байгаа боловч, эцсийн бүтээгдэхүүнийг худалдаанд гаргахдаа кг, жингийн зөвшөөрөгдөх хэлбэлзэлийн

хязгаарыг тодорхой тусгаагүй, үйлдвэрлэсэн өдрийг тэмдэглээгүй зэрэг зөрчил дутагдал гарсан тул савласан бүтээгдэхүүний тоо хэмжээ, он сар хугацаанд хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллуулах, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Өрсөлдөөний тухай хууль”, Зар сурталчилгааны тухай” хуулийг сурталчилсан.

Аймаг, сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж, “Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн сарын аян”-г зохион байгуулан хэрэгжилт 30 хувийн гүйцэтгэлтэй байна. Аянаар малын халдварт, паразиттах өвчин гарах, тархах, эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар малчид, мал бүхий иргэдэд зөвлөмж өгөх, хорогдсон малын сэг зэмийг булж устгах, цэвэрлэж халдваргүйжүүлэх, хотын ногоон байгууламжийн цэцэрлэгжүүлэх ажил эхлэхтэй холбогдуулан хараа хяналтгүй хотын ногоон бүст орж байгаа мал, амьтны эздийг тогтоон ногоон байгууламжийн хамгаалах зэрэг ажил арга хэмжээг зохион байгуулж, иргэдийн өвөлжөө хаваржааны газрын ойр орчим, гуу жалга, хогийн цэгт хаягдсан мал амьтны 12 сэг зэмийг цуглуулан булж устган ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлээ. Эхний 5 сарын байдлаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 төрлийн вакцинжуулалтанд бод 8620, бог 3000, амьтан 1500 нийт давхардсан тоогоор 13120 толгой мал амьтны хамруулах. паразит өвчинөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд бод 4400, бог 19000 нийт давхардсан тоогоор 23400 толгой мал амьтныг эмчлэн сэргийлэх арга хэмжээнд хамруулах, лабораторийн шинжилгээнд 287 толгой хээлтүүлэгч, 201 толгой хээлтэгч нийт 488 толгой хээлтэгч, хээлтүүлэгч малыг бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт шинжилгээнд хамруулах, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 89,3 мянган м² талбайд хийхээр төлөвлөж гэрээ байгууллаа.

Сүхбаатар суманд шинээр ажлын байр бий болгосон “Өнгөт хийц” ХХКомпани шинээр 42 ажлын байр бий болгож хөдөлмөрийн эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 46 иргэдийг “Залуу Сэлэнгэ” ХХК, “Өнгөт хийц” ХХК-д туслах ажилтан, үйлчлэгч, савх ялгагч, хөрөөчин өнгөлгөөчин, хэрчигч машины ажилтан, галчын ажлын байранд зуучилж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаас батласан 5 төсөл хөтөлбөр, ажил мэргэжилийн чиг баримжаа олгох зөвлөгөө мэдээлэлийг 8 багийн 21 иргэнд мэдээлэлээр ханган хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 14 иргэн, нийтийг хамарсан ажил зохион байгуулах 8 ажлын саналыг холбогдох байгууллагад цаг тухайд шилжүүлэн ажиллаа.

Засгийн газрын сум хөгжүүлэх сангийн журам, хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрийн талаар 37 иргэнд мэдээлэл өгч хэрхэн хамрагдах талаар сургалт, сурталчилгааг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээлийн санхүүжилт Голомт банкаар дамжуулан гаргах болсонтой холбоотой Сэлэнгэ аймгийн ХХҮГазар, АНУ-ын Олон улсын Хөгжлийн агентлаг REACH төсөл, “Голомт” банктай хамтран “Ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүд”-ийн сургалт зохион байгуулан төсөл боловсруулах аргачлал, зээлийн батлан даалтын сан, “Голомт” банкны зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас гарч байгаа төсөл хөтөлбөрийн мэдээлэл сургалтыг Сумын Жижиг дунд бизнес эрхлэгч 32 иргэнд зохион байгуулсан.

Сүхбаатар сумын Тохижилт үйлчигээний газар нь иргэдэд “Тохижилт үйлчилгээ Сэлэнгэ Сүхбаатар” facebook хаяг болон “Сүхбаатар хотын ТҮГ” page хуудас, SELENGE ZAR хаягаар өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаа болон багуудад ажиллах цагийн хуваарийг тухай бүр сумын ард иргэдэд тогтмол мэдээлэл өгч байгаа ба Хүдэр сумаас 250 ширхэг гацуурыг Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн зам талбайд шилжүүлэн суулгаж, усалгаа арчилгааг хариуцан ажиллаж байна.

Сумын хэмжээнд газар эзэмшиж буй газраа өмчлөхөөр 19 иргэн хүсэлт гаргаснаас 9 иргэний өргөдлийг бүртгэн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт хүргүүлж, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт газар өмчлүүлэхээр төлөвлөгдсөн газарт Сүхбаатар сумын иргэдээс өргөдөл авч эхэлсэн бөгөөд 8-н багийн Засаг дарга нарт шинээр газар өмчлүүлэхэд шаардлагатай материалын жагсаалт болон бусад суманд өмчлүүлж байгаа газрын байршлын талаар гарын авлага бэлтгэн тарааж, иргэдэд мэдээлэл хүргэж ажиллалаа.

2017 оны 4-р сарын орлогын гүйцэтгэлийг аймгийн Татварын албатай тооцоо нийлж баталгаажуулсан бөгөөд орон нутгийн орлогын гүйцэтгэл 118,3 хувийн гүйцэтгэлтэй төвлөрсөн байна. Хүү торгуулийн орлого, үйл ажиллагааны орлого, улсын тэмдэгтийн хураамж зэрэг орлогууд 135-159 хувиар давж биелсэн ба бусад нэр заагдаагүй орлого 20,8 хувийн биелэлттэй, орон нутгийн төсөвийн 05 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар татварын нийт 1.624.500 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэн 54,2 хувийн хэрэгжилттэй ажиллаа.

Жавхлант сум:

Монгол Улсын Засгийн газрын тэргүүн ерөнхий сайд Ж. Эрдэнэбат, ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн, аймаг, сумын удирдлагууд сумын хаврын тариалалт, "Хурниад" ХХК-н үйл ажиллагаатай танилцлаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн ээлжит 4-р хуралдаан хуралдаж сумын 2017 оны төсвийн тодотгол хийх, 40 жилийн ойг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, 40 жилийн ойн зардлын тооцоо, газар зохион байгуулалт, 40 жилийг тэмдэглэн өнгөрүүлэх өдрийн тов, орон нутгийн өмчийг өөрчлөн шилжүүлэх тухай зэрэг асуудлуудыг авч хэлэлцлээ.

ИТХурлын даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн малчин 76 айл өрхөд хүрч ажиллан сумын цаг үеийн мэдээ мэдээлэл, цаашид хийгдэх ажлын талаар мэдээлэл өгч, малын төл, хорогдлын мэдээ аван малчидтай малчин тариаланч, ногоочдын гурвалсан гэрээ байгуулан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

1, 2-р багийн иргэдийн нийтийн хурал энэ сарын 22-25-ны хооронд хөдөөгийн болон сумын төвийн иргэдийн дунд болж сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар 2017 оны хагас жилийн байдлаар сум орон нутагт зохион байгуулагдсан ажил үйлчилгээний талаар, сумын 40 жилийн ойг угтан хийж байгаа ажил, цаашид хийж гүйцэтгэх ажил, 40 жилийн хандивын талаар иргэддээ мэдээлэл хүргэн тэдний санал бодлыг сонсон ажиллаж өвөлжилтийг эрсдэлгүй даван туулсан сайн малчидаа урамшуулан шагналаа.

"Иргэдээ сонсоё" уулзалтыг зохион байгуулж сумын удирдлагууд оролцон цаг үеийн мэдээ мэдээлэл, сумын 40 жилийн ойг угтан хийж байгаа ажил, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар иргэддээ мэдээлэл хүргэн тэдний санал бодлыг сонсон төрийн захиргааны албан хаагчид өөр өөрсдийн чиглэлээр мэдээлэл өгөн гарын авлага боршур тараан ажиллаж иргэдээс гарсан гомдол саналын талаар ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллахаар боллоо.

Сумын Засаг даргын А/40 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган 18-25 насны 2-р зэргийн 54 бэлтгэл үүрэгтэнг аймгийн цэргийн штабын эрүүл мэндийн үзлэгт хамруулан 6 иргэн цэргийн албанд татагдсан.

2017 оны 05-р сарын 20-ны өдөр аймгийн МХГ-аас эрүүл мэнд, боловсрол, мал эмнэлэг, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг Жавхлант сумын ЗДТГ, Цэцэрлэг, ЕББДС, Эрүүл мэндийн төв болон тус суманд үйл ажиллагаа явуулж буй Багачууд дэлгүүр, Жавхлант Ачит тулга ХХК, Мөнх Сүрэг Эрдэнэ ХХК, Буянт Таван Эрдэнэ ХХК гэх мэт аж ахуйн нэгжүүдэд хийгдсэн.

2017 оны 05 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд авто техникийн улсын үзлэг явагдаж, 256 машин татвар төлж, тээврийн хяналтаар 316 машин хамрагдлаа.

Олон Улсын "Гэр бүлийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх сарын аяны төлөвлөгөө, удирдамжийн дагуу "Угийн бичиг хөтлөх" заавар зөвлөгөөг сумын нийт иргэдийн дунд зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай" сэдэвт ярилцлагыг зохион байгууллаа.

Сумын өрхийн эрүүл мэндийн төвөөр тайлант сард нийт 517 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэгт 380, амбулаторийн үзлэгт 35, идэвхитэй хяналтад 37, гэрийн идэвхитэй үзлэгээр 65 хамруулж, 14 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Дархлаажуулалтын 10 хоногийн аяны хүрээнд сумын 16-17 насны нийт 28 хүүхдийг улаанбурхан улаанууд өвчний эсрэг нэмэлт дархлаажуулалтанд хамрууллаа.

2017 онд 7673 га талбайд тариалалт хийхээс 5-р сарын 25-ны байдлаар 5460 га талбайд тариалалт хийсэн. Үүнд улаан буудай 11 аж ахуй нэгж - 4106 га талбайд,

тосны ургамал 2 аж ахуй нэгж- 1354 га талбайд төмс, хүнсний ногоо 130 га талбайд тариалалт хийхээс 47.8 га талбайд хийгээд байна.

"Цэвэр орчин-Эрүүл амьдрал" аяны хүрээнд 05-р сарын 13-ны өдөр буюу бямба гарагт бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, нийт 210 иргэн, ЕББДС-ийн 6-аас 12-р ангийн нийт 52 сурагчид сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж, талбайн ахуйн хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт буулгаж, 435100 төгрөгийг зарцуулсан.

Хушаат сум:

Аймгийн хөрөнгө оруулалт, сумын ОНХС-ийн болон "Хушаат нутгийн хөгжил сан"-гийн хөрөнгөөр 2017 оны хийгдэх сумын цэнгэлдэх хүрээлэн, морь барианы талбай байгуулах ажил, сумын зам засвар тэмдэг тэмдэглэгээ хийх болон гудамжны тохижилт, төв зам засварлах ажил, эрчим хүчний шугам татах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй болох, Ёслол хүндэтгэлийн өргөө барих зэрэг ажлуудын тендерийг сумын цахим хуудсаар нийтэд зарлаад байна.

Сумын ИТХ-ын 5-р сарын 19-ны хурлаар сумын төсвийн тодотголыг хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сумын Цагдаагийн хэсгээс тайлант сард гэмт хэргийн шинжтэй 1 гомдол мэдээллийг хүлээн авч материалжуулан мөрдөн байцаалтанд шилжүүлж, эргүүл шалгалтаар нийт 15 зөрчил илрүүлэн 8 хүнд сануулах арга хэмжээ авч 7 иргэнийг 92000 төгрөгөөр торгосон байна. Мөн байгаль орчны чиглэлээр зохион байгуулж буй арга хэмжээнд хяналт тавьж 9 тээврийн хэрэгсэл шалган байгаль орчин болон галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөө өглөө.

Тайлант сард төрөлт 3, цахим үнэмлэх дахин авах 3, биеийн давхцахгүй өгөгдлийн 4, газар өмчлөх эрхийн 1, иргэний үнэмлэх олголтын 9 нийт 20 бүртгэл хийгдлээ. Төрийн банкны орон нутгийн дансанд 23100, УБСГ-ын дансанд 105000 төгрөгийн орлого оруулж барьцааны гэрээ бүртгүүлэх, лавлагаа авах мэдүүлэг бичих талаар 8 иргэнд зөвлөгөөгч үл хөдлөх хөрөнгийн эрхийн 2, газар өмчлөх эрхийн 2 гэрчилгээг иргэдэд олгож, 4 иргэний гадаад паспортын сунгалтыг хийлгэсэн.

Татвар төлөгчдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөний дагуу ЕБС-ийн сурагчдын дунд "Татвар төлөгч танд баярлалаа" сэдвээр гар зураг, зохион бичлэгийн уралдаан зарлаж 9-10-р ангийн 18 хүүхэд оролцож зохион бичлэгийн уралдаанд 10-р ангийн сурагч Т.Мөнхцэцэг 1-р байр эзэлж Татварын Ерөнхий газрын даргын талархал дурсгалын зүйлээр, 2017 оны шилдэг татвар төлөгчөөр "Сэрдалай" ХХК, "Мөнхтолгой" 2-р багийн иргэн С.Мөнхбат нар шалгарч Татварын ерөнхий газрын шагналаар шагнагдсан.

Аймгийн Засаг даргын захирамжаар хийгдэж буй авто тээврийн хэрэгслийн үзлэгт 315 техник хамрагдаж, 11840,0 сая төгрөгийн татварыг төвлөрүүлэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын болон ЭМД-ын тухай хуулиудыг 514 хүнд танилцуулан нийгмийн даатгалд болон ЭМД-д малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд хамруулах талаар тараах материал гарын авлагыг 418 хүнд тарааж, 5-р сарын 24-ний байдлаар НДШ-д 29 байгууллага, аж ахуйн нэгжийн 93951,9 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 88 хүний 10977,9 мянган төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 96 хүний 3862,1 мянган төгрөгийн хураамжийг тус тус оруулаад байна. Шинээр тэтгэвэр тогтоолгох 10 хүний материалыг бодож баталгаажуулан тэтгэвэр тогтоолгох зөвлөгөөг 18 хүнд, ЭМД, НД-д сайн дураар даатгуулах зөвлөгөөг 214 хүнд өгч үйлчиллээ.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгож, ажил олгогч байгууллага, иргэнээс сул чөлөөтэй ажлын байрны захиалга авч 7 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа. Аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр болон малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдан зэл төлөх хугацаа хэтэрсэн зээлдэгчдэд мэдэгдэл өглөө. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөөг 15 иргэнд, бүлгийн зөвлөгөөг 3 бүлэгт өгч, сумын хүн ам, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн зарим үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр гаргалаа.

Олон улсын гэр бүлийн өдрийн хүрээнд “Аз жаргалын гүүр” ТББ-тай хамтран эцэг эх, өсвөр насны охидуудад зориулан “Гэр бүлийн үнэ цэнэ” сургалтыг зохион байгуулж, 46 иргэн хамрагдсан байна.

Цэцэрлэгийн хамран сургалт 5 сард бүх бүлэг нийт 2300 хүүхэд хүлээн авахаас 2000 хүүхэд авч ирц 86%-тай байна. Сургалтын цөм хөтөлбөр”-өөр үйл ажиллагаагаа бүлгүүдийн хөгжүүлэх үйл ажиллагаагаар хэвийн явагдаж байгаа ба Орхон бүсийн “Сайн хичээл, сайн үйл ажиллагаа”-д багш Б.Баясгалан, О.Бямбацэцэг нар амжилттай оролцсон. Мөн “Бүжгийн ертөнц” бүсийн тэмцээнээс Ахлах бүлгийн Аминаа 2-р байр мөнгөн медаль, Дунд бүлэг хамтлаг бүжгээр 3-р байр, “Уран жиргээ” тэмцээнийг зохион байгуулж Бэлтгэл бүлгийн Т.Түвшингэрэл 1-р байр, О.Оюунсүрэн 2-р байр, Ахлах бүлгийн Д.Аминаа 3-р байранд эзэлсэн.

Хаврын тариалалтын ажил эхэлж, сумын хэмжээнд үр тариа 9774 га, рапс 2429 га, гурвалжин будаа 148 га, төмс 189 га, хүнсний ногоо 61.5 га-д тариалж тариалалт хэвийн явагдаж байна.

Тайлант сард ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн ОБГ-ын албан хаагчидтай хяналтын постод ажиллаж, үр тарианы 6 аж ахуйн нэгжээр орж санамж зөвлөгөө, 145 иргэнд санамж, багуудын ИНХурлаар санамж анхааруулгыг иргэдэд өглөө.

Мод тарих үндэсний өдрөөр сумын хэмжээнд 1500 га-ад мод тарилаа. Хог хаягдлын цэвэрлэгээг айл өрхүүдээр тогтмол хийлгэж ажиллаж байна.

Гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга Мөнхтолгой 2-р багийн гүүр, талбулаг, рашаант, арын булаг, баянбулаг зэрэг газруудад 10534 хонь толгой хийгдсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй “Үндэсний болон орон нутгийн онцлогтой хоол, ундааг хөгжүүлэх нь” арга хэмжээний хүрээнд 2017 оны 5 дугаар сарын 26-28 ны өдрүүдэд Дархан-Уул аймагт Төв, Хангайн бүсийн сургалт, аварга тогооч, зөөгч шалгаруулах ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулагдах гэж байгаатай холбогдуулан ЭМТ-ийн эрхлэгч, ЕББДС-ийн захирал, СӨБ-ын эрхлэгч нарт мэдэгдэл хүргүүлж, ЕББДС-ийн ахлах тогооч, СӨБ-ын тогооч нарыг сургалтанд хамруулах болсон.

Малын “Сэг зэм” устгах ажлыг 2 удаа зохион байгуулж Жаргалант, доод бирваазны чиглэл, Мануултай, Голын хараат чиглэлд ажлын хэсэг гарган ажиллан сэг зэм булж ойр орчмын газрыг ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн. Нийтдээ хөдөөгийн 173 малчин, 74 мал бүхий өрхийн үүсгэсэн сэг зэмийг төвлөрсөн нүхэнд хийж булсан ба тогтоосон хугацаанд сэг зэмээ устгаагүй 55 малчинд хяналтын байцаагчийн зөвлөгөө, үүрэг даалгаварыг өгч ажиллалаа. Мөнхтолгой багийн 53 малчин өрх, мөнхтолгой багийн БИНХ-аар 68 хүн, Даагат багийн ИНХ-д 75 хүн нийт 196 өрхийн 302 хүнд малчдын зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх, МИД, малчдын аравтын зохион байгуулалт, болзолт уралдаан, мал үржлийн ажил, зохиомол хээлтүүлэг, мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний ач холбогдлын талаар сургалт мэдээлэл хийж гарын авлагаар хангалаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР